



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/436

Мөрөн сум

Тендерт оролцогчдод тавих шалгуур
үзүүлэлт, гэрээний загвар маягт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Сангийн сайдын 2021 оны 124, 144, 145, 146 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад мөрдөх “Нээлттэй тендер шалгаруулалтаар ажил худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг нэгдүгээр, харьцуулалтын аргаар ажил худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг хоёрдугаар, Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бараа худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг гуравдугаар, харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг дөрөвдүгээр, зөвлөх үйлчилгээ сонгох тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг тавдугаар, зөвлөхийн бус үйлчилгээ сонгох тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлал, тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагад нийцүүлэн захиалагчийн тендерийн баримт бичгийг боловсруулж, батлахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн захирал, удирдлагуудад тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА




Ш.ИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj

671 2011002

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар
сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт




ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР АЖИЛ ХУДАЛДАН
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан, Сангийн сайдын 2022 оны 137 дугаар тушаалаар оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.

2022 он

**II БҮЛЭГ. НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР
АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**



ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Хөвсгөл аймгийн Засаг дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газар</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]</i>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: багцын нэр, Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бичих]</i>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <i>[мөнгөн дүн бичих]</i> Үүнээс 202... онд санхүүжих дүн: <i>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг тухайн онд санхүүжих дүнгийн хамт бичих:</i> <i>Багцын нэр, дугаар: _____</i> <i>Багцын нэр, дугаар: _____]</i>
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 8.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>[хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бичих]</i> Хаяг: <i>Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар баг, Чингүүнжавын талбай, аймгийн удирдлагын ордны байр, Орон нутгийн өмчийн газар</i> Утасны дугаар: <i>[70388821, 70383809]</i> Цахим шуудангийн хаяг: <i>khuvs gul-tender.khs.gov.mn</i>

ТШЗ 9.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ["Тийм" эсхүл "Үгүй" гэж бич. Хэрэв "Тийм" бол уулзалт болох газар, огноо, цагийг бичих]
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бичих]
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: ["Зөвшөөрнө" эсхүл "Зөвшөөрөхгүй" гэж бичих].
ТШЗ 16.1	Ерөнхий нөхцлийг магадлах: ТШЗ-ийн 16.1, ТШЗ 16.2.1, ТШЗ 16.2.2, ТШЗ 16.2.3, 16.2.4 дэх хэсгүүдэд заасан баримт бичгийг үндэслэн тендерт оролцогч түүний түншлэгчдийн ерөнхий нөхцлийг магадлана. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
ТШЗ 16.2.1	Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэг, маргаанд оролцсон эсэх талаарх тодорхойлолт: "Шаардлагатай" Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. <i>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</i>
ТШЗ 16.2.2	Тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэрийн ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт шаардлагатай эсэх: "Шаардлагатай" <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж архивын лавлагаа авах хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт илгээх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хянан үзэж цахим хэлбэрээр ирүүлдэг болохыг анхаарна уу!</i> <i>Жич: Дээрх тодорхойлолт авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу</i>
ТШЗ 16.2.3	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем" www.tender.gov.mn болон "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.

	/Тендерт оролцогчийн өөрийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./
ТШЗ 16.2.4	Эрх бүхий болохыг нотлох баримт бичиг: Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй.
ТШЗ 17.2	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: ТШЗ-ийн 17.2.1, 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5, 17.3 дахь хэсгүүдэд заасан шалгуур үзүүлэлтээр санхүүгийн чадавхийг үнэлнэ.
ТШЗ 17.2.1	Харилцагч бакны өр төлбөргүй талаарх лавлагаа: "Шаардана": Хугацаа хэтэрсэн зээл, өр, төлбөртэй эсэх талаарх Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг өөрийн харилцагч банкнаас авч тендерт ирүүлнэ.
ТШЗ 17.2.3	Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
ТШЗ 17.2.4	Санхүүгийн тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын мэдээлэл: Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх ба тендерт оролцогч (түүний түншлэгчид) нь өөрийн хариуцах үүрэгт ноогдох дүнгээр дээрх үзүүлэлтийг хангана.
ТШЗ 17.2.5	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: "Шаардана" Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ <ul style="list-style-type: none"> • Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ. • Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;
ТШЗ 17.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг үнэлгээнд ашиглана. Дээрх онуудын санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй. Тендерт оролцогчийн санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж санхүүгийн чадавхийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг шалгана. Тендерт оролцогч ашигтай ажилласан болох нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна.
ТШЗ 17.6	Тендерт оролцогчийн техникийн чадавхийг ТШЗ-ийн 17.6.1, 17.6.2, 17.6.3, 17.6.4, 17.6.5 дахь хэсгүүдэд заасан туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага болон үүгээр хязгаарлахгүйгээр үнэлгээний хорооноос хуульд нийцүүлэн тогтоосон бусад үзүүлэлтээр үнэлнэ.

<p>ТШЗ 17.6.1</p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн ажилбарын дугаар нэрийг тодорхой бичих]</p> <p>Тусгай зөвшөөрөл шаардсан тохиолдолд тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. Харин зарим яамд, байгууллагаас олгодог тусгай зөвшөөрөлийн мэдээлэл “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем” дэх мэдээллийн санд ороогүй тул ийм ангилалд хамаарах тусгай зөвшөөрлийн эх хувь-аас татсан файлыг тендерийн баримт бичигт ирүүлнэ.</p> <p>Холбогдох тусгай зөвшөөрлийн цахим санд өөрийн компанийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл байгаа эсэхийг тендерт оролцогч нь нягтлан шалгах үүрэгтэйг анхаарна уу.</p>
<p>ТШЗ 17.6.2</p>	<p>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: “Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. (Хэрэв шаардах бол уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг үнэлгээний хороо тодорхой бичих ба эцэслэсэн тохиолдолд хаалтад байгаа хэсгийг устгана)</p> <p>1.Захиалагч хүний нөөцийн мэдээлэл шаардсан тохиолдолд уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчид (тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн ажилтан, ажилчид)-ын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 4 хүснэгтийн дагуу ирүүлнэ.</p> <p>2.Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.</p> <p>3.Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>4.Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээний мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. Ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p>


	<p>хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.</p> <p>7. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>8. Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 4 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх шаардлагатай. Тендерт оролцогч нь үндсэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг тендер нээгдэх өдрөөс өмнөх 3 сард тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул нийгмийн даатгалын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</p> <p>"Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс нийгмийн даатгал төлсөн эсэх мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ</p>
ТШЗ 17.6.3	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: "Шаардана"</p> <p>1. Энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж (тухайн ажлын хяналтын төсвөөр тодорхойлсон)-ийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтэд заасан зориулалт, шалгуур, шаардлагад нийцүүлэн санал болгоно.</p> <p>2. Бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэн ашиглах тохиолдолд Монгол улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг нийцэхүйц /хөлслөх/ гэрээг төсөл хэрэгжих хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулсан байна.</p> <p>3. Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтээр санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжүүдийн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх байх шаардлагатай.</p> <p>4. Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, холбогдох мэдээллийг тендерт ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой лавлагаа, бусад мэдээллийг цахим системээс шалгана.</p> <p>5. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 17.6.4	<p>1. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: "Шаардлагатай"</p> <p>Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 6, Маягт 7, Маягт 8 хүснэгтүүдээр ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээллийг ирүүлнэ. Гүйцэтгэл нь 100 хувьд хүрээгүй ажлыг ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад тооцохгүй.</p>

	<p>2. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>2.1. Сүүлийн 5 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон ажил түүнтэй ижил төстэй ажлын нэрийг бичих/.....ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>2.2. Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлагыг нотолж дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.2.1. Захиалагчтай байгуулсан гэрээ,</p> <p>2.2.2. Засгийн газрын “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журманд заасан байгууллага албан тушаалтны баталсан барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт (дүгнэлт)-ийн эх файл ирүүлэх.</p> <p>2.2.3. Дээрх ижил төсөвтэй ажилд тооцуулахаар санал болгосон ажлыг гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн тухай дараах захиалагч байгууллагуудын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзнэ. Үүнд:</p> <p>2.2.3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.3, 45.4 дэх хэсгүүдэд заасан захиалагч байгууллага,</p> <p>2.2.3.2. Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд</p> <p>2.2.3.3. Өмчийн бусад хэлбэрийн аж ахуйн нэгж</p>
ТШЗ 17.6.5	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: “Шаардана”</p> <p>Шаардана гэж захиалагч сонгосон тохиолдолд тендерт оролцогч доорх баримт бичгүүдийг өөрийн тендерт ирүүлнэ.</p> <p>1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар баталсан холбогдох маягтын дагуу боловсруулж, үе шатны хугацаанд хамаарах мөрүүдэд бичигдэх ажлыг мөнгөөр илэрхийж баталгаажуулан ирүүлнэ. Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь оны дугаар сарын-ны өдөр байна.</p> <p>2. Ажлыг гүйцэтгэх өртгийн төсвийг зураг, төсөл, захиалагчийн баталсан ажлын тоо хэмжээнд үндэслэн төсөв зохиох норм ба дүрмийн , эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам, зааврын дагуу төсөв зохиох программаар гүйцэтгэнэ/</p> <p>3. Хяналтын төсөвт тусгасан зураг төслийн үнэ/тоогоор/..... (...../үсгээр/.....) төгрөгийг өөрийн санал болгосон өртгийн төсөв /үнийн санал/-т багтаан тооцож ирүүлнэ.</p> <p>4. Захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардал, татварыг барилгын төсөв зохиох норм дүрмийн дагуу тооцон ажлын өртгийн төсөв, үнийн саналд шингээсэн байна.</p> <p>5. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, өөрийн ирүүлсэн төсвийн дүнтэй арифметик алдаанаас бусад тохиолдлоор зөрсөн, эсвэл үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт үзүүлсэн тендерээс тус тус татгалзана. Санал болгосон үнийн хөнгөлөлтийн дүн нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн бараа материалын үнээс бага байх тохиолдолд тухайн төсөлд санал болгосон үнийн хөнгөлөлтийг үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт гэж үзнэ.</p> <p>6. Тендерт оролцогч нь энэхүү тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу</p>

	<p>чанарын өндөр түвшинд гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>7. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягтад заасан нөхцөл, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдээгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>8. Тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлсэн тендерт оролцогчийн цахим хэлбэрээр ирүүлсэн тендерийн баримт бичиг нь бичиг хэргийн холбогдох стандартыг хангаагүй, уншигдахгүй, ойлгомжгүй байх зэрэг нь тус оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-тай танилцахыг зөвлөж байна.</p>
ТШЗ 17.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардана”</p> <p>Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 7, Маягт 8 хүснэгтүүдэд өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан бүх гэрээний мэдээлэлийг хүснэгтийн босоо багананд заасан өгөгдлийн дагуу үнэн зөв бичиж ирүүлнэ.</p>
ТШЗ 17.8	<p>Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна.</p> <p>Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагын өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох дараах баримт бичгийг тендерт ирүүлэх шаардлагатай Үүнд:</p> <p>1.Төлөөлөх эрх бүхий этгээд болон туслан гүйцэтгэгч нь төрийн худалдан авах авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.</p> <p>2.Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх ба ТШЗ-ны 17.6.1, 17.6.2-т заасан тусгай зөвшөөрөл болон хүний нөөцийн шаардлагыг өөрийн хариуцах үүргийн хувьд хангах ёстой.</p> <p>3.Туслан гүйцэтгэгчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. Иймд улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн регистрийн дугаарын мэдээллийг тендерт ирүүлнэ.</p>
ТШЗ 17.9	<p>Тендерт оролцогч нь түншлэлтэйгээр ажил гүйцэтгэх бол дор дурьдсан нөхцөл шаардлагыг хангаж, холбогдох баримт бичгийг тендерт ирүүлнэ.</p> <p>1.Төлөөлөх эрх бүхий этгээд болон түншлэгч нь төрийн худалдан авах авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.</p> <p>2.Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.</p>

	<p>3.ТШЗ-ны 17.2.4, ТШЗ-ны 17.2.5-д заасан борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6, 17.6.1, 17.6.2, 17.7-д заасан туршлага, тусгай зөвшөөрөл, хүний нөөц, гэрээний мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийг тус тус төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.</p> <p>4.Түншлэгчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана. Иймд улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй учир түншлэгч аж ахуйн нэгжийн регистрийн дугаарын мэдээллийг тендерт ирүүлнэ.</p>
ТШЗ 19.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "Тохируулахгүй тогтмол байна"
ТШЗ 22.1	<p>Тендерийн баталгааны дүн: [Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах багажцтай бол багц тус бүрээр доорх байдлаар заана:</p> <p>Багц №1: [●] төгрөг;</p> <p>Багц №2: [●] төгрөг.]</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 23.4	Тендер баталгаажуулах, илгээх: Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй
ТШЗ 23.6	<p>ТШЗ-ны 23.7-д зааснаас бусад баримт бичиг болон ТШЗ 16.1 болон V бүлгийн маягтуудаас гадна дараах баримт бичгийг тендерт оролцогчдод ил болгож илгээнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл; 2. Санал болгож буй ажил техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)-ны 18.1-т зааснаар тайлбарласан тайлбар; 3. Тендерт оролцогчийн тооцсон ажлын төсөв 4. Санал болгосон ажлыг гүйцэтгэх боломжтой болохыг нотлох баримт бичиг 5. Тендер санал болгосон ажиллах хүчний мэргэжил, туршлагын талаарх мэдээлэл 6. Тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл 7. Ижил төстэй ажилд тооцуулах гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тухайн ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолт 8. Тухайн ажлыг гүйцэтгэх үнийн санал, ажлын төсөв 9. ТШЗ-ны 17.2.4-д заасан борлуулалтын мэдээлэл, ТШЗ 17.2.5-д заасан гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ 17.6.5-д заасан баримт бичгүүд

	<p>10. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, тэдний хангавал зохих шалгуур шаардлагыг нотлох баримт бичиг</p> <p>11. ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн бүх баримт бичиг;</p>
ТШЗ 23.7	<p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг нууцлах: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 9-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p>
ТШЗ 24.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бичих]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бичих]</p>
ТШЗ 26.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бич. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бич. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</p> <p>Тендер нээх газрын хаяг: [аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 30.2	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]</p> <p>Хэрэв "Ашиглах" бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</p>
ТШЗ 33	<p>Тендерт оролцогчид давуу эрх олгох: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бөгөөд түүнийг ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, мөн хуулийн 10.1.2, 10.1.4, 10.1.7-д заасан этгээдийн ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7,5 хувиар хийсвэрээр бууруулж бусад оролцогчийн ирүүлсэн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч давуу эрх тооцуулах бол хүсэлт болон дараах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.1. Ажилд ашиглах материал бүтээц хийцийн гарал үүсэл, үнэ өртгийн талаарх мэдээлэл,</p> <p>2.2. Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягуудын Маягт 4 хүснэгтэд санал болгосон ажиллах хүчний 50-аас доошгүй хувь нь Хөвсгөл аймгийн харъяат иргэд болохыг нотлох нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.2.1.Иргэний үнэмлэх,</p> <p>2.2.2.иргэний оршин суугаа хаягын бүртгэлийн лавлагааг e-mongolia нэгдсэн системээс авч ирүүлнэ.</p>



Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1 Мэдэгдэл хүргэсэнд тооцох	Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн V бүлгийн жишиг маягтуудын МАЯГТ 1 буюу тендер илгээх маягтад зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.
ТШЗ 39.1	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих]</i> <i>[Хэрэв "Тийм" гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих:</i> <i>ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]</i>
Ё. БУСАД	
ТШЗ 41.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <i>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих]</i> <i>[Хэрэв "Тийм" гэж хариулсан бол гэрээний үнийн дүнгийн хэдэн хувьтай тэнцүү хэмжээний урьдчилгаа төлбөр олгохыг доор бичих:</i> <i>Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : гэрээний үнийн дүнгийн [•] хувь</i> <i>Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлнэ.]</i>
ТШЗ 43.1	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй <i>[Хэрэв "Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам"-аар зохион байгуулах бол "Тийм" гэж бичих]</i>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

[Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Зураг төсөл, загвар зураг

Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД



Маягт 1	Тендер илгээх маягт	2
Маягт 2	Тендерийн баталгаа (банкны)	3
Маягт 3 ..	Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)	5
Маягт 4	Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл	7
Маягт 5	Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл	7
Маягт 6	Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл	7
Маягт 7	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	8
Маягт 8	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	8
Маягт 9	Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт	7

Маягт 4**Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл**


Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 5**Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 6**Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/



Маягт 7 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 9

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт



	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

**НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.3.	<i>Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.</i>
ГЕН 4.4	Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
ГЕН 4.5	Гэрээний ерөнхий нөхцлийн 10.16 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн үед Гүйцэтгэгчийн хүсэлтээр гэрээг нэг удаа сунгаж болно.
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.10	<i>Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</i>
ГЕН 4.11	Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: [“Тийм”, “Үгүй” аль нэгийг сонгох] Хэрвээ урьдчилгаа төлбөр олгох бол: Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: [мөнгөн дүн бич]
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: [ажлын хоног бичих]
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.8.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа шаардана/ шаардахгүй] <i>Чанарын баталгаа шаардах бол,</i> Чанарын баталгааны хэмжээ: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонго.]
ГЕН 6.14.	Баталгаат хугацаа: [Тендерийн баримт бичигт үндэслэн баталгаат хугацааг тогтоож бичих]
ГЕН 7.5.	Даатгал: [Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]

ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Гүйцэтгэгч ажлыг ашиглалтад хүлээлгэн өгч, ажлын гүйцэтгэлтэй холбогдох баримт бичгийг захиалагч талд хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 20 хоногийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд энэ хугацаанаас хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлнө.
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Тийм” , Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Ажил дуусгах хугацааг гэрээнд заасан өдрөөс хоцроосон тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ҮЕД ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

(Гэрээний маягт нь барилгын ажилд зориулагдсан бөгөөд барилгын ажлаас өөр бусад ажлын гэрээ байгуулах бол гэрээний маягтад өөрчлөлт оруулах үүргийг захиалагч болон үнэлгээний хороо хариуцна)

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

ЗӨВШӨӨРСӨН:

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... хот/аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг 202.. оны сарын ...-ны өдөр дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байх бөгөөд санхүүжилтийг гэрээний 5 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн хуваарийн дагуу олгоно.

1.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

1.2. Санхүүжилтийн нийт дүн:

Үүнээс: 202.. онд санхүүжих дүн:

2. Энэхүү гэрээт ажлыг 202... оны ... дугаар сарын ... –ны дотор дуусгаж ашиглалтад оруулна.

3. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

4.2. Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;

4.3. Ажлын зураг төсөл, гүйцэтгэгчийн тендерт ирүүлсэн өртгийн төсөв;

4.4. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний ерөнхий нөхцөл)

4.5. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл)

4.6. Гэрээний 3 дугаар хавсралт(Барилга байгууламжийн ажлын үе шатанд хийх

ажлын хуваарь):

4.7. Гэрээний 4 дүгээр хавсралт (Ажил, материал, бүтээц хийцийн техникийн тодорхойлолт

4.8. Гэрээний 5 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);

4.9. Гэрээний 6 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй гүйцэтгэлийн баталгаа);

4.10. Гэрээний 7 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);

4.11. Гэрээний 8 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг⁷);

5. Ажлын зураг төслийг Гүйцэтгэгч хянан үзэж зөвшөөрсөн болно.

6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг

баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

8. Ажил нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

9. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, тендерт заасан ажлын болон материалын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд хамаарах ажилбарын нэр зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

11. Захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 9 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

13. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

13.1. Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл, холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

13.2. Захиалагч талыг төлөөлж зохиогчийн болон техник хяналтыг гүйцэтгэх эрх бүхий мэргэжлийн байгууллагын ажилтан (захиалагчийн төлөөлөгч)-ыг гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна.

13.3. Захиалагч нь гэрээт ажлын гүйцэтгэл, үе шатны хуваарьт заасан үйл ажиллагаа, хугацаа, чанар, бүтээмжид байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

13.4. Гүйцэтгэгч талд хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагааны талаар холбогдох хууль журмыг сахин ханган ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

13.5. Талууд хамтран үе шатны хуваарьт заасан ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тухайн үе шатны ажил эхлэх өдөр, дуусах өдөрт тус тус авч, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, төсвийг баталгаажуулж, захиалагч, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэн, энэ тухай мэдээллийг www.tender.khs.gov.mn сайт болон холбогдох бусад мэдээллийн хэрэгсэлд тухай бүр нийтэлж, ил тод байдлыг хангана.

13.6. Хэрэв Гүйцэтгэгч ажлыг зураг төсвийн дагуу хийгээгүй, стандарт болон технологи зөрчсөн, чанаргүй хийсэн зэрэг доголдол ажлын явцад илэрвэл ажлыг зогсоож доголдлыг арилгуулахыг шаардах, дахин гүйцэтгүүлэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

13.7. Хэрэв ажлын шаардлага хангахгүй материал ашиглан барилгын ажлыг гүйцэтгэсэн тохиолдолд үе шатны хуваарьт заасан тухайн ажлыг хүлээн авахаас татгалзах, Гүйцэтгэгч талд албан бичгээр шуурхай мэдэгдэх, буцаах, солиулах, хохирлыг төлүүлэх зэрэг шаталсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

13.8. Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтийг Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан байгууллагад хүргүүлж, ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг шийдвэрлүүлнэ.

13.9. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд шаардагдах дараах нөхцлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:



13.9.1. Гэрээт ажлыг гүйцэтгэх шаардлагатай ажлын талбайг бэлтгэж, хүлээлгэн өгөх, буцааж хүлээн авах

13.9.2. Гэрээт ажилтай холбогдох зураг, баримт бичиг бүрдүүлэх

13.9.3. Цахилгаан, дулаан, ус болон шаардлагатай нөхцөлд гэрээнд нэмэлтээр тусгасан бусад зүйлсээр хангах;

13.10. Захиалагч энэ гэрээний 13.9 дахь хэсэгт заасан ажлын нөхцөл бүрдсэн тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлнэ.

13.11. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас ажлын талбайд байгаа эд хөрөнгөд гэмтэл учирсан тохиолдолд түүнийг засах, нөхөн сэргээх албан шаардлагыг Гүйцэтгэгчид бичгээр гаргаж мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

13.12. Ажлын үе шатны явцын талаар санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон захиалагчийн төлөөлөгч албан бичгээр Гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

13.13. Ажлын талбайн орчинд байх хүн, байгаль орчинд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас хамаарч үүсч болзошгүй аюул занлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах, хэрэгжилтэд хяналт тавих

13.14. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

13.15. Ажлын гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэсэн ажлын хэмжээнд тохируулан үр дүнгээр нь санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн 30-аас доошгүй хувийн санхүүжилтийг барилгын ажлыг дуусган улсын комисст хүлээлгэн өгч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

13.16. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилтийн явцын мэдээлэл болон гэрээг дүгнэж, ажлыг хүлээн авсан баримт бичиг, гүйцэтгэлийн зураг, төсөв, тайланг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тухай бүр ирүүлэх бөгөөд тус газар нь гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, www.tender.khs.gov.mn сайтад нийтлэх үүрэг хүлээнэ.

13.17. Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: /...../ төгрөг
 - Захиалагчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Магадлашгүй ажил: /...../ төгрөг
- Зураг төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийгдэх болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

13.18. Захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн ажлыг ашиглалтад хүлээн авах, гэрээний төлбөрийн санхүүжилтийн хуваарийн дагуу төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх үүрэг хүлээнэ.

13.19. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь хэсэгт заасан хугацаанд чанаргүй болон дутуу гүйцэтгэлийн улмаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, материал бүтээцэд гарсан зөрчил, гологдлыг арилгах, хохиролыг нөхөн төлөх мэдэгдлийг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэх ба Гүйцэтгэгч нь мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор зөрчил, гологдол, чанаргүй гүйцэтгэлийг засварлаагүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 13.14-т заасан барьцаа хөрөнгөөр засварын ажлыг гүйцэтгэж, барьцаа хөрөнгөөс давсан зардлыг гүйцэтгэгчээс нэхэмжилж авах эрх эдлэнэ.

13.20. Энэхүү гэрээний үүргийг “хангалттай” гүйцэтгэсэн бол уг гүйцэтгэгчийг “ногоон”, “хангалтгүй” гүйцэтгэсэн бол уг гүйцэтгэгчийг “хар” хуудсанд тус тус бүртгэх ба захиалагч нь “хар” хуудсан бүртгэгдсэн этгээдийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандах эрх эдэлнэ.

14. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

14.1. Гүйцэтгэгч тал нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан “Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг”, гэрээнд заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлэх бөгөөд барилгын стандарт, дүрэм, норм нормативыг баримтлан ажиллана.

14.2. Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5-д заасны дагуу хөдөлмөр хамгааллын инженер томилж, ажлын байранд хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагааг хангахын зэрэгцээ, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлж, гамшиг, аюулт үзэгдлийн үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх;

14.3. Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдыг энэхүү ажилд ажиллуулах бөгөөд ажилтан, ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

14.4. Ажлыг батлагдсан зураг төсөл, гэрээ, барилгын ажлын норм ба дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж, үе шатны хуваарьт заасан хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөх, захиалагчтай байгуулсан гэрээг дүгнүүлэх үүрэгтэй.

14.5. Лабораторийн шинжилгээ, чанарын сертификат, тохиролын гэрчилгээтэй материал, бүтээцийг барилгын ажилд ашиглана.

14.6. Ажлын үе шатны хуваарьт заасан ажил эхлэх, дуусах өдрүүдэд захиалагчийн төлөөлөгчийг ирүүлж, ажлын гүйцэтгэлийг хянуулах, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг төсөл, өртгийн төсвийг батлуулах, шинээр эхлэх үе шатны ажилд ашиглах материал, бүтээцийг угсралтын ажилд ашиглах зөвшөөрөл авах үүргүүдийг хүлээнэ.

14.7. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн төлөөлөгчийн гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг тухай бүр хэрэгжүүлж биелэлт үр дүнг захиалагчийн төлөөлөгчид тайлагнана.

14.8. Гүйцэтгэгч тал нь Захиалагчийн төлөөлөгч, ашиглалт хариуцсан байгууллагын ажилтнуудтай ажил хэргийн тэгш харилцаатай ажиллана.

14.9. Гүйцэтгэгч нь ажилчдыг ажлын талбай, түүний орчинд архидан согтуурах, танхайрах, дураараа сэлгүүцэх, хог тарих, захиалагч, ашиглагчаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх зэрэг ёс зүйн болоод эрх зүйн зөрчил гаргуулахгүй байх асуудлыг хариуцна.

14.10. Энэхүү гэрээгээр талууд ажил, материалын тоо хэмжээ, барилгын ажил гүйцэтгэх хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зөрүү, гэрээний хүчинтэй хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, материалын үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

14.11. Гүйцэтгэгч тал нь барилгын ил далд ажлын акт, барилгын ажлын явцын фото зураг зэрэг холбогдох баримт бичгүүдийн эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг ашиглагчийн томилогдсон ажилтанд тухай бүр танилцуулан, хүлээлгэн өгнө.

14.12. Захиалагч болон олон нийтийн зүгээс талаас ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр тухай бүр мэдэгдэнэ.

14.13. Барилгын ажилд аюулгүй ажиллагааг хангах хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулан захиалагчийн төлөөлөгчөөр батлуулж мөрдөнө.

14.14. Гүйцэтгэгч нь тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид, туслан гүйцэтгэгч, түншлэгчээс бусад этгээдээр ажил гүйцэтгүүлэх, зуучлахыг хориглоно.

14.15. Монгол улсын барилгын тухай хуулийн 14.3-т заасан барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааны **1 жил**, барилгын тухай хуулийн 14.6-т заасан **барилга** байгууламжийг зүгшрүүлэх, тохируулах хугацааны 3 жилийн хугацаанд ажлын гүйцэтгэлээс хамаарч үүссэн аливаа гологдол, гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг засварлах, гарсан хохиролыг нөхөн төлөх үүргийг гүйцэтгэгч хүлээх бөгөөд захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд эвдрэл гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг засварлан ажлыг захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

14.16. энэ гэрээний 14.15-д заасан чанаргүй гүйцэтгэл, эвдрэл, гэмтлийг захиалагчийн заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд тухайн эвдрэл гэмтлийг гэрээний 13.14-т заасан чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс гаргахыг захиалагч талд гүйцэтгэгч тал зөвшөөрнө. Хэрэв дээрх гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг арилгахад чанарын баталгааны барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй болж нэмэлт зардал гарвал хэтэрсэн зардлыг Гүйцэтгэгчээс гаргуулна.

14.17. Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг ажил дууссан тухай мэдэгдэл (Улсын комиссын акт) гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Гэрээт ажил дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгаа чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

14.18. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын гэрээний дүн, санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх дуусан хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан 2,0 метрээс багагүй урттай, 1,5 метрээс багагүй өргөнтэй метал хавтан, метал багана бүхий самбарыг бүтээн байгуулалтаар бий болсон объектын дэргэд 4 жилийн хугацаанд олон нийтэд харагдахуйцаар байршуулна.

14.19. Гүйцэтгэгч нь гэрээт ажлын үе шат бүрийн хэрэгжилтийн явц болон ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөхтэй холбоотой гүйцэтгэлийн мэдээлэл, баримт бичиг, фото зургыг www.tender.khs.gov.mn сайтад тухай бүр нийтэлнэ.

15. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

15.1. Гүйцэтгэгч нь ажлын тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

15.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

15.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

15.4. Гүйцэтгэгч нь захиалагчаас хүлээн авсан ажлын талбай болон түүнд хамаарах барилга байгууламж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

15.5. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Захиргааны ерөнхий хууль", "Иргэний хууль", "Барилгын тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, гэрээний ерөнхий, тусгай нөхцөлд заасан хариуцлагыг хүлээнэ.

15.6. Гүйцэтгэгчийн хүсэлт болон түүний гэм буруугийн улмаас гэрээ цуцалсан тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн өгөх үүргийг уг гүйцэтгэлийн баталгааг байршуулсан банк хариуцна.

15.7. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

16. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

16.1. Дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдвол гэрээг цуцалж болно. Үүнд:

16.1.1. Талууд гэрээ, гэрээний тусгай болон ерөнхий нөхцөлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний ерөнхий нөхцлийн 9.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

16.1.2. Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл ажлын үе шатны хуваарьт заасан ажил хийгдээгүй,

16.1.3. барилгын ажлын гүйцэтгэлийг хийхдээ мэргэжлийн алдаа гаргаж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахгүй материалыг ажилд ашигласан

16.1.4. Гүйцэтгэгч захиалагчийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй,

16.1.5. Гэрээний талууд гэрээний үүргээсээ татгалзсан

16.2. Гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай хуанлийн 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

16.3. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

17. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

17.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.

17.2. Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан "ажил худалдан авах ажиллагаа"-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 4 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

17.3. Хэрэв гэрээний хэрэгжилтийн явцад нэмэлт гэрээ байгуулсан бол уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

17.4. Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд гэрээний 13.14, 13.18, 13.19, 13.20 дах заалтууд нь "Барилгын тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан хугацаа болон чанаргүй гүйцэтгэл, гэмтэл, эвдрэлийг Гүйцэтгэгч засварлаж дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

18. ГЭРЭЭ ДҮГНЭХ

18.1. Захиалагч болон гүйцэтгэгч, зохиогч байгууллагууд хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.

18.2. Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

18.3. Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийсэн тухай техник хяналтын нэгдсэн дүгнэлт болон Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан баримт бичгийг захиалагчаас аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

18.4. Байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах асуудлыг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар зохион байгуулна.

19. ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

19.1. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

19.1.1 Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

19.1.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

.....

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН

ГАЗРЫН ДАРГА

.....

ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар
сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн хоёр дугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ХУДАЛДАН
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 124 дугаар тушаалын хавсралтаар баталсан, *Сангийн сайдын 2022 оны 137 дугаар тушаалаар оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.*

2022 он

**II БҮЛЭГ. ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР
АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Хөвсгөл аймгийн Засаг дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газар</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бич]</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бич]</i>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: багцын нэр, Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бич]</i>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <i>[мөнгөн дүн бич]</i> <i>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бич:</i> <i>Багц №...: _____</i> <i>Багц №...: _____]</i>
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 8.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>[хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бич]</i> Хаяг: <i>[хүсэлт хүлээн авах хаягийг бич]</i> Утасны дугаар: <i>[албан байгууллагын утасны дугаарыг бич]</i> Цахим шуудангийн хаяг: <i>[албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бич]</i>
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 11.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <i>["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бич]</i>


ТШЗ 14.1	<p>Ерөнхий нөхцлийг магадлах: ТШЗ 14.1, ТШЗ 14.2.1, ТШЗ 14.2.2, ТШЗ 14.2.3 дахь хэсгүүдэд заасан баримт бичгийг үндэслэн тендерт оролцогч түүний түншлэгчдийн ерөнхий нөхцлийг магадлана. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг V бүлгийн Error! Reference source not found.-ийн дагуу ирүүлнэ.</p>
ТШЗ 14.2.1	<p>Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэг, маргаанд оролцсон эсэх талаарх тодорхойлолт: “Шаардлагатай” <i>Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим хэлбэрээр авна.</i></p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p><i>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</i></p>
ТШЗ 14.2.2	<p>Тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэрийн ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт шаардлагатай эсэх: “Шаардлагатай”</p> <p><i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж архивын лавлагаа авах хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт илгээх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хянан үзэж цахим хэлбэрээр ирүүлдэг болохыг анхаарна уу!</i></p> <p><i>Жич: Дээрх тодорхойлолт авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу</i></p>
ТШЗ 14.2.3	<p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p><i>/Тендерт оролцогчийн өөрийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</i></p>
ТШЗ 14.2.4	<p>Эрх бүхий болохыг нотлох баримт бичиг: Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй.</p>
ТШЗ 15.2	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: ТШЗ-ийн 15.2.1, 15.2.2, 15.2.3, 15.2.4, 15.2.5, 15.3 дахь хэсгүүдэд заасан шалгуур үзүүлэлтээр санхүүгийн чадавхийг үнэлнэ.</p>
ТШЗ 15.2.1	<p>Харилцагч бакны өр төлбөргүй талаарх лавлагаа: “Шаардана”:</p>

	Хугацаа хэтэрсэн зээл, өр, төлбөртэй эсэх талаарх Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг өөрийн харилцагч банкнаас авч тендерт ирүүлнэ.
ТШЗ 15.2.2	Сүүлийн 2 жил (2021, 2022 онууд)-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
ТШЗ 15.2.3	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил (2021, 2022 онууд)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх
ТШЗ 15.2.4	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт “Шаардана” Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ <ul style="list-style-type: none"> • Арлжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ. • Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;
ТШЗ 15.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 2 жилийн тайланг үнэлгээнд ашиглана. Дээрх онуудын санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй. Тендерт оролцогчийн санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж санхүүгийн чадавхийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг шалгана. Тендерт оролцогч ашигтай ажилласан болох нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна.
ТШЗ 15.6	Тендерт оролцогчийн техникийн чадавхийг ТШЗ-ийн 15.6.1, 15.6.2, 15.6.3, 15.6.4, 15.6.5 дахь хэсгүүдэд заасан туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага болон үүгээр хязгаарлахгүйгээр үнэлгээний хорооноос хуульд нийцүүлэн тогтоосон бусад үзүүлэлтээр үнэлнэ.
ТШЗ 15.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн ажилбарын дугаар нэрийг тодорхой бичих] Тусгай зөвшөөрөл шаардсан тохиолдолд тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн

	<p>материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. Харин зарим яамд, байгууллагаас олгодог тусгай зөвшөөрөлийн мэдээлэл "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем" дэх мэдээллийн санд ороогүй тул ийм ангилалд хамаарах тусгай зөвшөөрлийн эх хувь-аас татсан файлыг тендерийн баримт бичигт ирүүлнэ.</p> <p>Холбогдох тусгай зөвшөөрлийн цахим санд өөрийн компанийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл байгаа эсэхийг тендерт оролцогч нь нягтлан шалгах үүрэгтэйг анхаарна уу.</p>
ТШЗ 15.6.2	<p>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: "Шаардана"</p> <p>1. Уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчид (тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн ажилтан, ажилчид)-ын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 2 хүснэгтийн дагуу ирүүлнэ.</p> <p>2. Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.</p> <p>3. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>4. Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээний мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. Иймд ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p> <p>5. Төсөлд санал болгосон ажилтан, ажилчид нь гадаад улсын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас татсан файлыг тендерт ирүүлнэ.</p> <p>6. Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, ажилчдад хамаарахгүй инженер, техникийн ажилтан, ажилчдыг төсөлд санал болгосон бол тэдэнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.</p> <p>7. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>8. Захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 2 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх шаардлагатай. Тендерт оролцогч нь</p>


	<p>үндсэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг тендер нээгдэх өдрөөс өмнөх 3 сард тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул нийгмийн даатгалын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</p> <p>"Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс нийгмийн даатгал төлсөн эсэх мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ</p>
<p>ТШЗ 15.6.3</p>	<p>1.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: "Шаардлагатай"</p> <p>Захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 3, Маягт 4 хүснэгтээр ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээллийг ирүүлнэ. Ажлын гүйцэтгэл нь 100 хувьд хүрээгүй ажлыг ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад тооцохгүй.</p> <p>2.Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>2.1.Сүүлийн 2 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон ажил түүнтэй ижил төстэй ажлын нэрийг бичих/.....ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>2.2.Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлагыг нотолж дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.2.1.Захиалагчтай байгуулсан гэрээ,</p> <p>2.2.2.Засгийн газрын "Дүрэм шинэчлэн батлах тухай" 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан журманд заасан байгууллага албан тушаалтны баталсан барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт (дүгнэлт)-ийн эхээс хийсэн хуулбар</p> <p>2.2.3. Дээрх ижил төсөвтэй ажилд тооцуулахаар санал болгосон ажлыг гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн тухай дараах захиалагч байгууллагуудын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзнэ. Үүнд:</p> <p>2.2.3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.3, 45.4 дэх хэсгүүдэд заасан захиалагч байгууллага,</p> <p>2.2.3.2.Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд</p> <p>2.2.3.3.Өмчийн бусад хэлбэрийн аж ахуйн нэгж</p>
<p>ТШЗ 15.6.4</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: "Шаардана"</p> <p>1.Энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж (тухайн ажлын хяналтын төсвөөр тодорхойлсон)-ийг захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтэд заасан зориулалт, шалгуур, шаардлагад нийцүүлэн санал болгоно.</p> <p>2.Бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэн ашиглах тохиолдолд Монгол улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг нийцэхүйц /хөлслөх/ гэрээг төсөл хэрэгжих хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулсан байна.</p>

	<p>3.Захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтээр санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжүүдийн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх байх шаардлагатай.</p> <p>4.Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, холбогдох мэдээллийг тендерт ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой лавлагаа, бусад мэдээллийг цахим системээс шалгана.</p> <p>5.Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<p>ТШЗ 15.6.5</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: "Шаардана"</p> <p>Тендерт оролцогч доорх баримт бичгүүдийг өөрийн тендерт ирүүлнэ.</p> <p>1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар баталсан холбогдох маягтын дагуу боловсруулж, үе шатны хугацаанд хамаарах мөрүүдэд бичигдэх ажлыг мөнгөөр илэрхийж баталгаажуулан ирүүлнэ. Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь оны дугаар сарын-ны өдөр байна.</p> <p>2. Ажлыг гүйцэтгэх өртгийн төсвийг зураг, төсөл, захиалагчийн баталсан ажлын тоо хэмжээнд үндэслэн төсөв зохиох норм ба дүрмийн , эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам, зааврын дагуу төсөв зохиох программаар гүйцэтгэнэ/</p> <p>3. Хяналтын төсөвт тусгасан зураг төслийн үнэ/тоогоор/..... (...../үсгээр/.....) төгрөгийг өөрийн санал болгосон өртгийн төсөв /үнийн санал/-т багтаан тооцож ирүүлнэ.</p> <p>4. Захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардал, татварыг барилгын төсөв зохиох норм дүрмийн дагуу тооцон ажлын өртгийн төсөв, үнийн саналд шингээсэн байна.</p> <p>5. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, өөрийн ирүүлсэн төсвийн дүнтэй арифметик алдаанаас бусад тохиолдлоор зөрсөн, эсвэл үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт үзүүлсэн тендерээс тус тус татгалзана. Санал болгосон үнийн хөнгөлөлтийн дүн нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн бараа материалын үнээс бага байх тохиолдолд тухайн төсөлд санал болгосон үнийн хөнгөлөлтийг үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт гэж үзнэ.</p> <p>6. Тендерт оролцогч нь энэхүү тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>7. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягтад заасан нөхцөл, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>8. Тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлсэн тендерт оролцогчийн цахим хэлбэрээр ирүүлсэн тендерийн баримт бичиг нь бичиг хэргийн холбогдох стандартыг хангаагүй, уншигдахгүй, ойлгомжгүй байх зэрэг нь тус оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим</p>

	<p>системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-тай танилцахыг зөвлөж байна.</p> 
<p>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</p>	
<p>ТШЗ 20.4</p>	<p>Тендер илгээх: <i>Хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээс итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд нь өөрийн гарын үсэг, эсхүл тоон гарын үсгээр тендерийг баталгаажуулсан байна.</i></p> <p><i>Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 20.1-д зааснаар тамга, тэмдэгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</i></p>
<p>ТШЗ 20.6</p>	<p>ТШЗ-ны 20.7-д зааснаас бусад баримт бичиг, ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;</i> 2. <i>Санал болгож буй ажил техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг тендер шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ)-ны 16.1-т зааснаар тайлбарласан тайлбар;</i> 3. <i>Тендерт оролцогчийн тооцсон ажлын төсөв</i> 4. <i>Санал болгосон ажлыг гүйцэтгэх боломжтой болохыг нотлох баримт бичиг</i> 5. <i>Тендер санал болгосон ажиллах хүчний мэргэжил, туршлагын талаарх мэдээлэл</i> 6. <i>Тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл</i> 7. <i>Ижил төстэй ажилд тооцуулах гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тухайн ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолт</i> 8. <i>Тухайн ажлыг гүйцэтгэх үнийн санал</i> 9. ТШЗ 15.2.4-д заасан гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ 15.6.5-д заасан баримт бичгүүд 10. ТШЗ-ны 16.2-д заасан тайлбар
<p>ТШЗ 20.7</p>	<p>Нууцлах баримт бичиг: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн 6-ын дагуу нууцлахгүйгээр илгээнэ.</p>
<p>ТШЗ 21.1.</p>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бич]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бич]</p>

ТШЗ 23.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <i>[он, сар, өдрийг бич. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бич. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</i></p> <p>Тендер нээх газрын хаяг: <i>[аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</i></p>
ТШЗ 27.2	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглана”</p> <p>Тендерт оролцогчид давуу эрх олгох: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бөгөөд түүнийг ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар, мөн хуулийн 10.1.2, 10.1.4, 10.1.7-д заасан этгээдийн ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7,5 хувиар хийсвэрээр бууруулж бусад оролцогчийн ирүүлсэн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч давуу эрх тооцуулах бол хүсэлт болон дараах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.1. Ажилд ашиглах материал бүтээц хийцийн гарал үүсэл, үнэ өртгийн талаарх мэдээлэл,</p> <p>2.2. Захиалагчийн тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 2 хүснэгтэд санал болгосон ажиллах хүчний 50-аас доошгүй хувь нь Хөвсгөл аймгийн харъяат иргэд болохыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.2.1.Иргэний үнэмлэх,</p> <p>2.2.2.иргэний оршин суугаа хаягын бүртгэлийн лавлагааг e-mongolia нэгдсэн системээс авч ирүүлнэ.</p>
ТШЗ 34.1 Мэдэгдэл хүргэсэнд тооцох	<p>Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн V бүлгийн жишиг маягтуудын МАЯГТ 1 буюу тендер илгээх маягтад зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.</p>
Ё. БУСАД	
ТШЗ 37.1	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <i>[“Тийм” эсхүл “Үгүй” гэж бич]</i></p> <p><i>[Хэрэв “Тийм” гэж хариулсан бол гэрээний үнийн дүнгийн хэдэн хувьтай тэнцүү хэмжээний урьдчилгаа төлбөр олгохыг доор бич:</i></p>

Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : гэрээний үнийн дүнгийн [●]
хувь



III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

[Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа, үйлчилгээнд ~~тавигдах~~ шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Зураг төсөл, загвар зураг

Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана.

Үе шатны ажлын хуваарь

Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн нэг маягийн загвар зураг, техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандартыг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулна.]



IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 31.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил гүйцэтгэх хуваарь: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]**

Хэрэв "ашиглах" бол: Тухайн тендер шалгаруулалтанд холбогдох гэрээний дагуу үе шатны ажлын хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (ажил гүйцэтгэж эхлэх хамгийн эхний өдрөөс хойш ажил гүйцэтгэж дуусах хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) гүйцэтгэх шаардлагатай. Үе шатны ажлын хуваарьт заасан хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд үе шатны ажлын хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бич]**-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Ажлыг үе шатны ажлын хуваарьт зааснаас **[тоо бич]**-аас илүү **["сар", "өдөр" гэдэг үгнээс сонгож бич]** хоцроож гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон хугацаанаас хойш гүйцэтгэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тендерт санал болгосон ажил болон болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын үед шаардагдах урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]**

Хэрэв "ашиглах" бол тендерт санал болгосон ажлын **[тоо бич]** **["сар", "өдөр", "жил" гэдэг үгнээс сонгож бич]** хугацаанд шаардагдах урсгал зардлын хэмжээг тооцоолж ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

Мөн тендерийн дагуу санал болгосон ажлын үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлж болно.

3. Тендерт санал болгосон ажлыг хүлээлгэж өгсөний дараах үйлчилгээг үзүүлэх боломж: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич.]**

Хэрэв "ашиглах" бол урсгал засвар хийх болон үндсэн/шаардлагатай бараа материал, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материалаар хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.


4. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн ажил гүйцэтгэх тендерийн харьцуулах үнийг хэрхэн тодорхойлох шалгуур үзүүлэлтийг энд бич.

Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.]

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД



Маягт 1 Тендер илгээх маягт 2

Маягт 2 Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл 3

Маягт 3 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл 3

Маягт 4 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл 4

Маягт 5 Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл 5

Маягт 6 Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт 6

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-ын нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бич].** **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бич].**
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 11.4 болон 14.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2**Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл**

Албан тушаал	Ажилтны нэр	Нийт ажлын туршлага, жилээр	Ижил төстэй ажлын туршлага, жилээр

Маягт 3**Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4**Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*


1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 5**Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 6

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт



	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМ БИЧГИЙН ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

(Гэрээний маягт нь барилгын ажилд зориулагдсан бөгөөд өөр барилгын ажлаас өөр бусад ажлын гэрээ байгуулах бол гэрээний маягтад өөрчлөлт оруулах үүргийг захиалагч болон үнэлгээний хороо хариуцна)

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

ЗӨВШӨӨРСӨН:

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... хот/аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг 202.. оны сарын ...-ны өдөр дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Ажил" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байх бөгөөд санхүүжилтийг гэрээний 5 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн хуваарийн дагуу олгоно.

1.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

1.2. Санхүүжилтийн нийт дүн:

Үүнээс: 202.. онд санхүүжих дүн:

2. Энэхүү гэрээт ажлыг 202... оны ... дугаар сарын ... –ны дотор дуусгаж ашиглалтад оруулна. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан үндэслэл тогтоогдвол ажил дуусах дуусах хугацааг 1 удаа сунгаж болно

3. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

4.2. Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;

4.3. Ажлын зураг төсөл, гүйцэтгэгчийн тендерт ирүүлсэн өртгийн төсөв;

4.4. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний ерөнхий нөхцөл)

4.5. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл)

4.6. Гэрээний 3 дугаар хавсралт(Барилга байгууламжийн ажлын үе шатанд хийх ажлын хуваарь²):

4.7. Гэрээний 4 дүгээр хавсралт (Ажил, материал, бүтээц хийцийн техникийн тодорхойлолт

4.8. Гэрээний 5 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);

4.9. Гэрээний 6 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);

4.11. Гэрээний 7 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг³);

5. Ажлын зураг төслийг Гүйцэтгэгч хянан үзэж зөвшөөрсөн болно.

² Нэгж үнийн гэрээнд "үе шатны ажлын хуваарь" гэснийг "ажлын тоо хэмжээ" гэж солино.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

8. Ажил нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

9. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, ажлын болон материалын тоо хэмжээ зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

11. Захиалгч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 9 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

12. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

13. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

13.1. Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйл, холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

13.2. Захиалагч талыг төлөөлж зохиогчийн болон техник хяналтыг гүйцэтгэх эрх бүхий мэргэжлийн байгууллагын ажилтан (захиалагчийн төлөөлөгч)-ыг гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна.

13.3. Захиалагч нь гэрээт ажлын гүйцэтгэл, үе шатны хуваарьт заасан үйл ажиллагаа, хугацаа, чанар, бүтээмжид байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

13.4. Гүйцэтгэгч талд хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагааны талаар холбогдох хууль журмыг сахин ханган ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

13.5. Талууд хамтран үе шатны хуваарьт заасан ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тухайн үе шатны ажил эхлэх өдөр, дуусах өдөрт тус тус авч, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, төсвийг баталгаажуулж, захиалагч, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэн, энэ тухай мэдээллийг www.tender.khs.gov.mn сайт болон холбогдох бусад мэдээллийн хэрэгсэлд тухай бүр нийтэлж, ил тод байдлыг хангана.

13.6. Хэрэв Гүйцэтгэгч ажлын зураг төсвийн дагуу хийгээгүй, стандарт болон технологи зөрчсөн, чанаргүй хийсэн зэрэг доголдол засварын ажлын явцад илэрвэл ажлыг зогсоож доголдлыг арилгуулахыг шаардах, дахин гүйцэтгүүлэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

13.7. Хэрэв ажлын шаардлага хангахгүй материал ашиглан барилгын ажлыг гүйцэтгэсэн тохиолдолд үе шатны хуваарьт заасан тухайн ажлыг хүлээн авахаас татгалзах, Гүйцэтгэгч талд албан бичгээр шуурхай мэдэгдэх, буцаах, солиулах, хохирлыг төлүүлэх зэрэг шаталсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

13.8. Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтийг Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан байгууллагад хүргүүлж, ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг шийдвэрлүүлнэ.

13.9. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд шаардагдах дараах нөхцлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

13.9.1. Гэрээт ажлыг гүйцэтгэх шаардлагатай ажлын талбайг бэлтгэж, хүлээлгэн өгөх, буцааж хүлээн авах

13.9.2. Гэрээт ажилтай холбогдох зураг, баримт бичиг бүрдүүлэх

13.9.3. Цахилгаан, дулаан, ус болон шаардлагатай нөхцөлд гэрээнд нэмэлтээр тусгасан бусад зүйлсээр хангах;

13.10. Захиалагч энэ гэрээний 13.9 дахь хэсэгт заасан ажлын нөхцөл бүрдсэн тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлнэ.

13.11. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас ажлын талбайд байгаа эд хөрөнгөд гэмтэл учирсан тохиолдолд түүнийг засах, нөхөн сэргээх албан шаардлагыг Гүйцэтгэгчид бичгээр гаргаж мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

13.12. Ажлын үе шатны явцын талаар санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон захиалагчийн төлөөлөгч албан бичгээр Гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

13.13. Ажлын талбайн орчинд байх хүн, байгаль орчинд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас хамаарч үүсч болзошгүй аюул занлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах, хэрэгжилтэд хяналт тавих

13.14. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

13.15. Барилгын ажлын гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэсэн ажлын хэмжээнд тохируулан үр дүнгээр нь санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн 30-аас доошгүй хувийн санхүүжилтийг барилгын ажлыг дуусган улсын комисст хүлээлгэн өгч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

13.16. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн явцын мэдээлэл болон гэрээг дүгнэж, ажлыг хүлээн авсан баримт бичиг, тайланг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тухай бүр ирүүлэх бөгөөд тус газар нь гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, www.tender.khs.gov.mn сайтад нийтлэх үүрэг хүлээнэ.

13.17. Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: /...../ төгрөг
 - Захиалагчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: /...../ төгрөг
 - Магадлашгүй ажил: /...../ төгрөг
- Зураг төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийгдэх болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

13.18. Захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн ажлыг

ашиглалтад хүлээн авах, гэрээний төлбөрийн санхүүжилтийн хуваарийн дагуу төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх үүрэг хүлээнэ.

13.19. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь хэсэгт заасан хугацаанд чанаргүй болон дутуу гүйцэтгэлийн улмаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, материал бүтээцэд гарсан зөрчил, гологдлыг арилгах, хохиролыг нөхөн төлөх мэдэгдлийг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэх ба Гүйцэтгэгч нь мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор зөрчил, гологдол, чанаргүй гүйцэтгэлийг засварлаагүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 13.14-т заасан барьцаа хөрөнгөөр засварын ажлыг гүйцэтгэж, барьцаа хөрөнгөөс давсан зардлыг гүйцэтгэгчээс нэхэмжилж авах эрх эдлэнэ.

13.20. Энэхүү гэрээний үүргийг “хангалттай” гүйцэтгэсэн бол уг гүйцэтгэгчийг “ногоон”, “хангалтгүй” гүйцэтгэсэн бол уг гүйцэтгэгчийг “хар” хуудсанд тус тус бүртгэх ба захиалагч нь “хар” хуудсан бүртгэгдсэн этгээдийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандах эрх эдэлнэ.

14. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

14.1. Гүйцэтгэгч тал нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан “Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг”, гэрээнд заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлэх бөгөөд барилгын стандарт, дүрэм, норм нормативыг баримтлан ажиллана.

14.2. Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5-д заасны дагуу хөдөлмөр хамгааллын инженер томилж, ажлын байранд хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагааг хангахын зэрэгцээ, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлж, гамшиг, аюулт үзэгдлийн үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх;

14.3. Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдыг энэхүү ажилд ажиллуулах бөгөөд ажилтан, ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

14.4. Ажлыг батлагдсан зураг төсөл, гэрээ, барилгын ажлын норм ба дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж, үе шатны хуваарьт заасан хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөх, захиалагчтай байгуулсан гэрээг дүгнүүлэх үүрэгтэй.

14.5. Лабораторийн шинжилгээ, чанарын сертификат, тохиролын гэрчилгээтэй материал, бүтээцийг барилгын ажилд ашиглана.

14.6. Ажлын үе шатны хуваарьт заасан ажил эхлэх, дуусах өдрүүдэд захиалагчийн төлөөлөгчийг ирүүлж, ажлын гүйцэтгэлийг хянуулах, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг төсөл, өртгийн төсвийг батлуулах, шинээр эхлэх үе шатны ажилд ашиглах материал, бүтээцийг угсралтын ажилд ашиглах зөвшөөрөл авах үүргүүдийг хүлээнэ.

14.7. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн төлөөлөгчийн гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг тухай бүр хэрэгжүүлж биелэлт үр дүнг захиалагчийн төлөөлөгчид тайлагнана.

14.8. Гүйцэтгэгч тал нь Захиалагчийн төлөөлөгч, ашиглалт хариуцсан байгууллагын ажилтнуудтай ажил хэргийн тэгш харилцаатай ажиллана.

14.9. Гүйцэтгэгч нь ажилчдыг ажлын талбай, түүний орчинд архидан согтуурах, танхайрах, дураараа сэлгүүцэх, хог тарих, захиалагч, ашиглагчаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх зэрэг ёс зүйн болоод эрх зүйн зөрчил гаргуулахгүй байх асуудлыг хариуцна.

14.10. Энэхүү гэрээгээр талууд ажил, материалын тоо хэмжээ, барилгын ажил гүйцэтгэх хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зөрүү, гэрээний хүчинтэй

хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, материалын үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

14.11. Гүйцэтгэгч тал нь барилгын ил далд ажлын акт, барилгын ажлын явцын фото зураг зэрэг холбогдох баримт бичгүүдийн эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг ашиглагчийн томилогдсон ажилтанд тухай бүр танилцуулан, хүлээлгэн өгнө.

14.12. Захиалагч болон олон нийтийн зүгээс талаас ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр тухай бүр мэдэгдэнэ.

14.13. Барилгын ажилд аюулгүй ажиллагааг хангах хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулан захиалагчийн төлөөлөгчөөр батлуулж мөрдөнө.

14.14. Гүйцэтгэгч нь ажлыг тендерт санал болгосон туслан гүйцэтгэгч, түншлэгчээс бусад этгээдээр гүйцэтгүүлэх, зуучлахыг хориглоно.

14.15. Монгол улсын барилгын тухай хуулийн 14.3-т заасан барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааны **1 жил**, барилгын тухай хуулийн 14.6-т заасан **барилга** байгууламжийг зүгшрүүлэх, тохируулах хугацааны 3 жилийн хугацаанд ажлын гүйцэтгэлээс хамаарч үүссэн аливаа гологдол, гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг засварлах, гарсан хохиролыг нөхөн төлөх үүргийг гүйцэтгэгч хүлээх бөгөөд захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд эвдрэл гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг засварлан ажлыг захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

14.16. энэ гэрээний 14.15-д заасан чанаргүй гүйцэтгэл, эвдрэл, гэмтлийг захиалагчийн заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд тухайн эвдрэл гэмтлийг гэрээний 13.14-т заасан чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс гаргахыг захиалагч талд гүйцэтгэгч тал зөвшөөрнө. Хэрэв дээрх гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг арилгахад чанарын баталгааны барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй болж нэмэлт зардал гарвал хэтэрсэн зардлыг Гүйцэтгэгчээс гаргуулна.

14.17. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын гэрээний дүн, санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх дуусан хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан 2,0 метрээс багагүй урттай, 1,5 метрээс багагүй өргөнтэй металл хавтан, металл багана бүхий самбарыг бүтээн байгуулалтаар бий болсон объектын дэргэд 4 жилийн хугацаанд олон нийтэд харагдахуйцаар байршуулна.

14.18. Гүйцэтгэгч нь гэрээт ажлын үе шат бүрийн хэрэгжилтийн явц болон ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөхтэй холбоотой гүйцэтгэлийн мэдээлэл, баримт бичиг, фото зургыг www.tender.khs.gov.mn сайтад тухай бүр нийтэлнэ.

15. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

15.1. Гүйцэтгэгч нь ажлын тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

15.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

15.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

15.4. Гүйцэтгэгч нь захиалагчаас хүлээн авсан ажлын талбай болон түүнд хамаарах барилга байгууламж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

15.5. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Захиргааны ерөнхий хууль", "Иргэний хууль", "Барилгын тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, гэрээний ерөнхий, тусгай нөхцөлд заасан хариуцлагыг хүлээнэ.

15.6. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

16. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

16.1. Дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдвол гэрээг цуцалж болно. Үүнд:

16.1.1. Талууд гэрээ, гэрээний тусгай болон ерөнхий нөхцөлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний ерөнхий нөхцлийн 9.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

16.1.2. Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл ажлын үе шатны хуваарьт заасан ажил хийгдээгүй,

16.1.3. барилгын ажлын гүйцэтгэлийг хийхдээ мэргэжлийн алдаа гаргаж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахгүй материалыг ажилд ашигласан

16.1.4. Гүйцэтгэгч захиалагчийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй,

16.1.5. Гэрээний талууд гэрээний үүргээсээ татгалзсан

16.2. Гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай хуанлийн 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

16.3. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

17. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

17.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.

17.2. Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан "ажил худалдан авах ажиллагаа"-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 4 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

17.3. Хэрэв гэрээний хэрэгжилтийн явцад нэмэлт гэрээ байгуулсан бол уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

17.4. Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд гэрээний 13.14, 13.18, 13.19, 13.20 дах заалтууд нь "Барилгын тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан хугацаа болон чанаргүй гүйцэтгэл, гэмтэл, эвдрэлийг Гүйцэтгэгч засварлаж дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

18. ГЭРЭЭ ДҮГНЭХ

18.1. Захиалагч болон гүйцэтгэгч, зохиогч байгууллагууд хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.

18.2. Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

18.3. Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийсэн тухай техник хяналтын нэгдсэн дүгнэлт болон Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан баримт бичгийг захиалагчаас аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

18.4. Байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах асуудлыг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар зохион байгуулна.

19. ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

19.1. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

19.1.1 Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

19.1.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА

.....


ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

Аймгийн Засаг даргын 2022 оны 12
дугаар сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн гурав дугаар хавсралт




ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР БАРАА ХУДАЛДАН
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалын
хавсралтаар баталсан, Сангийн сайдын 2022 оны 136 дугаар тушаалаар нэмэлт,
өөрчлөлтийг оруулсан жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.

2022 он

**II БҮЛЭГ. НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР БАРАА ХУДАЛДАН
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**



ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>[захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]</i>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: багцын нэр, Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <i>Дотоодын багц № 3: багцын нэр, Дотоодын багц № 4: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бичих]</i>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <i>[мөнгөн дүн бичих]</i> <i>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бичих:</i> <i>Үүнээс: 202... онд санхүүжих дүн:</i> <i>Багц тус бүрийн санхүүжих дүн:</i> <i>Багцын нэр дугаар: _____</i> <i>Багцын нэр дугаар: _____]</i>
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>[хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бичих]</i> Хаяг: <i>[хүсэлт хүлээн авах хаягийг бичих]</i> Утасны дугаар: <i>[албан байгууллагын утасны дугаарыг бичих]</i>

	Цахим шуудангийн хаяг: [албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бичих]
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ["Тийм" эсхүл "Үгүй" гэж бич. Хэрэв "Тийм" бол уулзалт болох газар, огноо, цагийг бичих]
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 13.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бичих]
ТШЗ 16.1	Хувилбарт санал ирүүлэхийг: ["Зөвшөөрнө" эсхүл "Зөвшөөрөхгүй" гэж бичих].
ТШЗ 17.1	Ерөнхий нөхцлийг магадлах: ТШЗ 17.1, ТШЗ 17.2.1, ТШЗ 17.2.2, ТШЗ 17.2.3 дахь хэсгүүдэд заасан баримт бичгийг үндэслэн тендерт оролцогч түүний түншлэгчдийн ерөнхий нөхцлийг магадлана. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг V бүлгийн Error! Reference source not found. -ийн дагуу ирүүлнэ.
ТШЗ 17.2.1	<p>Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэг, маргаанд оролцсон эсэх талаарх тодорхойлолт: "Шаардлагатай" Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим хэлбэрээр авна.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p>Жич: Тендерт оролцогч дээрх лавлагааг хэрхэн авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 17.2.2	<p>Тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэрийн ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт шаардлагатай эсэх: "Шаардлагатай"</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан архивын лавлагаа авах хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт илгээх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хянан үзэж цахим хэлбэрээр ирүүлдэг болохыг анхаарна уу!</p> <p>Жич: Тендерт оролцогч дээрх лавлагааг хэрхэн авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 17.2.3	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.

	<p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p>/Тендерт оролцогчийн өөрийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй/</p>
ТШЗ 17.2.4	<p>Эрх бүхий болохыг нотлох баримт бичиг: Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй.</p>
ТШЗ 18.2.1	<p>Харилцагч бакны өр төлбөргүй талаарх лавлагаа: “Шаардана”: Хугацаа хэтэрсэн зээл, өр, төлбөртэй эсэх талаарх Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг өөрийн харилцагч банкнаас авч тендерт ирүүлнэ</p>
ТШЗ 18.2.3	<p>Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;</p>
ТШЗ 18.2.4	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><i>Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх ба тендерт оролцогч (түүний түншлэгчид) нь өөрийн хариуцах үүрэгт ноогдох дүнгээр дээрх үзүүлэлтийг хангаж, эдгээр онуудад ашигтай ажилласан байна.</i></p>
ТШЗ 18.2.5	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана” Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. <i>Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</i></p> <p><i>Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/</i></p> <ul style="list-style-type: none"> • Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ. <p><i>Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;</i></p>
ТШЗ 18.3	<p>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг үнэлгээнд ашиглана. Дээрх онуудын санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй. Тендерт оролцогчийн санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж санхүүгийн чадавхийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг шалгана. <i>Тендерт оролцогч ашигтай ажилласан болох нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна.</i></p>
ТШЗ 18.6.1	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бичих]</p>

ТШЗ 18.6.2	<p>Барааг өөрөө үйлдвэрлээгүй бол барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт: “Шаардана”</p> <p>Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгосон тохиолдолд Захиалагчийн тендерийн баримт бичгийн I бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны ерөнхий зүйлийн ТШЗ 18.6.2 дугаар хэсэгт заасан нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй холбоотой баримт бичгийг ирүүлнэ.</p>												
ТШЗ 18.6.3	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Барааг ашиглахын тулд суурилуулах, турших, тохируулах, хүний нөөцийг сургах зэрэг үйлчилгээ авах тохиолдолд “Шаардана” гэж сонгож уг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих]</p> <p>1. Захиалагч хүний нөөцийн мэдээлэл шаардсан тохиолдолд уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг дор дурьдсан хүснэгтээр ирүүлнэ.</p> <table border="1" data-bbox="460 889 1393 1038"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүн ий Тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td>Диплом ирүүлэх шаардлагагүй.</td> </tr> </tbody> </table> <p>2. Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.</p> <p>3. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>4. Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээний мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. Ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p> <p>5. Төсөлд санал болгосон ажилтан, ажилчид нь гадаад улсын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас татсан файлыг тендерт ирүүлнэ.</p> <p>6. Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, ажилчдад хамаарахгүй инженер, техникийн ажилтан, ажилчдыг төсөлд санал болгосон бол тэдэнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд</p>	№	Албан тушаал	Хүн ий Тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх						Диплом ирүүлэх шаардлагагүй.
№	Албан тушаал	Хүн ий Тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх								
					Диплом ирүүлэх шаардлагагүй.								

	<p>гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.</p> <p>7. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>8. Дээрх хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх шаардлагатай. Тендерт оролцогч нь үндсэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг тендер нээгдэх өдрөөс өмнөх 3 сард тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул нийгмийн даатгалын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</p> <p>"Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс нийгмийн даатгал төлсөн эсэх мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ</p>
<p>ТШЗ 18.6.4</p>	<p>1.Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: "Шаардлагатай" Сүүлийн 5 жилд энэхүү тендерээр худалдан авах бараатай ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагад хамаарах гэрээний мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 5, маягт 6, Маягт 7 хүснэгтүүдэд заасан өгөгдлийн дагуу ирүүлнэ.</p> <p>2.Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: [Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо барааны онцлог, тоо хэмжээг харгалзан зайлшгүй шаардлагыг тусгана. Тухайлбал дараах шаардлагууд байж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</p> <p>2.1.Сүүлийн 5 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон бараа түүнтэй ижил төстэй барааны нэрийг бичих/.....барааг нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. Энэхүү тендерийн дагуу нийлүүлэх төсөл арга хэмжээ (багц)-нд хамаарах бараатай дүйцэхүйц зориулалт, шинж чанар, зориулалт бүхий барааны нийлүүлэлтийг ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагад тооцно.</p> <p>2.2 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагад тооцуулах гэрээтэй холбоотой дараах мэдээллийг тендерт ирүүлнэ.</p> <p>2.2.1. Барааг нийлүүлэхээр захиалагчтай байгуулсан гэрээ</p> <p>2.2.2. Барааг хүлээн авсан акт,</p> <p>2.2.3. Захиалагчтай байгуулсан гэрээг дүгнэсэн акт,</p> <p>2.2.4. Ижил төстэй бараа нийлүүлэлтэд тооцуулахаар санал болгосон барааг гэрээний хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолтыг дор дурьдсан байгууллагуудаас ирүүлснийг үнэлгээнд харгалзан үзнэ.</p> <p>2.2.4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.3, 45.4 дэх хэсгүүдэд заасан захиалагч байгууллага,</p> <p>2.2.4.2.Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд</p>


ТШЗ 18.6.6	<p>Нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээ: Үнэлгээний хороо “шаардлагатай” эсхүл “шаардлагагүй” эсэхийг сонгоно.</p> <p><i>Шаардлагатай гэж сонгосон тохиолдолд тендерт оролцогч нь нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээг хэрэхэн үзүүлэх тухай баримт болон мэдээллийг ирүүлнэ.</i></p>												
ТШЗ 18.6.7	<p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв тэсрэх бодис, шингэн болон хийн төлөвт байгаа нефтийн бүтээгдэхүүн, тусгай зориулалтын машин механизм, зэрэг барааг тээвэртэй нийлүүлэлтээр худалдан авахаас бусад тохиолдолд тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж шаардахгүй.]</p> <p><i>Энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг шаардлагатай гэж сонгосон бол тендерт оролцогч тэдгээрийг доорх хүснэгтэд заасан зориулалт, шалгуур, шаардлагад нийцүүлэн санал болгоно.</i></p> <table border="1" data-bbox="460 801 1398 965"> <thead> <tr> <th data-bbox="460 801 539 965">№</th> <th data-bbox="539 801 802 965">Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</th> <th data-bbox="802 801 915 965">Хүчин чадал</th> <th data-bbox="915 801 1067 965">Тоо ширхэг</th> <th data-bbox="1067 801 1208 965">Улсын дугаар</th> <th data-bbox="1208 801 1398 965">Эзэмшигчийн мэдээлэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="460 965 539 965"></td> <td data-bbox="539 965 802 965"></td> <td data-bbox="802 965 915 965"></td> <td data-bbox="915 965 1067 965"></td> <td data-bbox="1067 965 1208 965"></td> <td data-bbox="1208 965 1398 965"></td> </tr> </tbody> </table> <p><i>2. Бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэн ашиглах тохиолдолд Монгол улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг нийцэхүйц /хөлслөх/ гэрээг төсөл хэрэгжих хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулсан байна.</i></p> <p><i>3. Дээрх хүснэгтээр санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжүүдийн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх байх шаардлагатай.</i></p> <p><i>4. Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, холбогдох мэдээллийг тендерт ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой лавлага, бусад мэдээллийг цахим системээс шалгана.</i></p> <p><i>5. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>	№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар	Эзэмшигчийн мэдээлэл						
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар	Эзэмшигчийн мэдээлэл								
ТШЗ 18.6.8	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: "Шаардана"</p> <ol style="list-style-type: none"> <i>1. Барааны үнийн задаргааг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 2 хүснэгтээр бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ.</i> <i>2. Бараа нийлүүлэлтийн хуваарийг захиалагчийн тендерийн баримт бичгийн III бүлгийн 4 дүгээр хуудсанд заасан "бараа нийлүүлэлтийн хуваарь" маягтад заасан мэдээллийн дагуу бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ.</i> <i>3. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</i> 												

	<p>4. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ.</p>
ТШЗ 18.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэж бичих]</p> <p>Үнэлгээний хороо шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 6-ын дагуу ирүүлнэ.</p>
ТШЗ 18.9.	<p>Тендерт оролцогч түншлэгч, туслан гүйцэтгэгч ажиллуулах санал гаргавал түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь дараах шалгуур үзүүлэлт, шаардлагын өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх үүрэгт хамааруулан ТШЗ 18.6.1-д заасан тусгай зөвшөөрөл, ТШЗ 18.6.3-т заасан хүний нөөц, ТШЗ 18.6.7-д заасан тээврийн хэрэгсэл, машин механизмтай байх шаардлагуудаас өөрт ноогдох хэсгийг хангана. 2. Түншлэл нь ТШЗ-ны 17, 18.6-д заасан шалгуурын доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. ТШЗ-ны 18.2.4, 18.2.5-т борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 18.6.3, ТШЗ-ны 18.6.4, ТШЗ-ны 18.6.7-д заасан ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлт, 18.6.1-т заасан тусгай зөвшөөрөлийг тус тус заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. 3. Төлөөлөх эрх бүхий этгээд болон туслан гүйцэтгэгч, түншлэгч нь төрийн худалдан авах авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.
ТШЗ 19.1	<p>Барааны гарал үүсэлийн мэдээлэл ирүүлэх: "Шаардлагатай"</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэхээр санал болгосон бараа нь Захиалагчийн тендерийн баримт бичгийн I бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны ерөнхий зүйлийн ТШЗ-ны 7 дугаар зүйлд заасан гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ. 2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
ТШЗ 19.4	<p>Санал болгосон бараа тендерийн баримт бичигт нийцснийг нотлох баримт бичиг:</p>

	<ol style="list-style-type: none"> 1. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг захиалагчийн тендерийн баримт бичгийн III бүлгийн 3 дугаар хуудсанд заасан "техникийн тодорхойлолт" маягтад харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хэлбэрээр бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ. 2. Санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтыг хангаж буйг нотлох баримт шаардах эсэх: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв захиалагч шаардана гэж сонговол тендерт оролцогч барааны загвар дээжийг ирүүлнэ.] 3. Бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтыг нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, стандарт, катлогийн дугаар хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн үнэн зөвөөр харьцуулсан тайлбар, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарт дурдсан байна.
ТШЗ 19.5.	<p>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа: [Хугацааг тодорхой бичих, уг хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж, эд зүйлсийг жагсааж бичих]</p>
ТШЗ 19.5.	<p>Тендерт оролцогчид давуу эрх олгох: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бөгөөд түүнийг ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар хийсвэрээр бууруулж бусад оролцогчийн ирүүлсэн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч давуу эрх тооцуулах бол дараах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.1. Ажилд ашиглах материал бүтээц хийцийн гарал үүсэл, үнэ өртгийн талаарх мэдээлэл,</p> <p>2.2. Хуулийн 10 дугаар зүйлийн дагуу давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичиг.</p> <p>2.3. Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт</p> <p>Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.</p>
ТШЗ 20.5.	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "Тохируулахгүй тогтмол байна"</p>
ТШЗ 20.6	<p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: ["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих. Хэрэв "Тийм" бол Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарын аль нөхцөлөөр, хаана хүргүүлэх болохыг доорх байдлаар тодорхой бич. Жишээ нь: Incoterms 2020, DDP, бараа хүргэх газар]</p>

ТШЗ 23.1	<p>Тендерийн баталгааны дүн: [Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц, тус бүрээр доорх байдлаар заана:</p> <p>Багц №1: [●] төгрөг;</p> <p>Багц №2: [●] төгрөг.]</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 24.4	<p>Тендерийг баталгаажуулах, илгээх: Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 24.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p>
ТШЗ 24.5	<p>ТШЗ-ны 24.7-д зааснаас бусад баримт бичиг болон ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага; 2. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ 3. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршилагын шалгуур үзүүлэлт, шаардлага; 4. Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл 5. Барааг дамжуулан борлуулах зөвшөөрөл; 6. Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл; 7. Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл; 8. Техникийн чадавх болон туршилагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт; 9. Тендерт оролцогч түншлэгч, туслан гүйцэтгэгчдийн мэдээлэл 10. Тендерт оролцогчид давуу эрх олгохтой холбоотой баримт бичиг 11. Санал болгосон бараа тендерийн баримт бичигт нийцснийг нотлох баримт бичиг: /ТШЗ 19.4-д заасан
ТШЗ 24.7	<p>Нууцлах баримт бичиг: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Error! Reference source not found.-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p>
ТШЗ 25.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бичих]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бичих]</p>

ТШЗ 27.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <i>[он, сар, өдрийг бичих. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</i></p> <p>Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бичих. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</i></p> <p>Тендер нээх газрын хаяг: <i>[аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</i></p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.2	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <i>["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]</i></p> <p><i>Хэрэв "Ашиглах" бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</i></p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 38.1 Мэдэгдэл хүргэсэнд тооцох	<p>Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн V бүлгийн жишиг маягтуудын МАЯГТ 1 буюу тендер илгээх маягтад зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.</p>
ТШЗ 40.1	<p>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих]</i></p> <p><i>[Хэрэв "Тийм" гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих:</i></p> <p><i>ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]</i></p>
Ё. БУСАД	
ТШЗ 43.1	<p>Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй</p> <p><i>[Хэрэв "Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам"-аар зохион байгуулах бол "Тийм" гэж бичих]</i></p>



III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч тендерт оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.



Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1		3	4	5	6	7
1	[Барааны нэрийг бичих]	[нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2020.10.01-ээс 2020.10.14]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2						
3						
...						

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]**

Хэрэв "ашиглах" бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **["сар", "өдөр" гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]**

Хэрэв "ашиглах" бол тендерт санал болгосон барааны **[тоо бичих]** **["сар", "өдөр", "жил" гэдэг үгнээс сонгож бичих]** хугацаанд шаардагдах урсгал зардлын хэмжээг тооцоолж ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

Мөн тендерийн дагуу санал болгосон барааны үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлж болно.

3. Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих.]**

Хэрэв "ашиглах" бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

4. Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшгүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]**

Ашиглалтын эхний хугацааны дотор шаардагдаж болох гол эд анги, бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээний жагсаалтыг барааны жагсаалтад оруулсан байна. Ингэхдээ гол эд анги бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн үнийг тендерийн үнээс тусад нь ирүүлэх ёстой. Тендер бүрийн үнийн саналд дурдсан нэгж үнэд тулгуурлан дээрх жагсаалтад орсон эд зүйлсийн нийт үнийг тендерийн үнэ дээр үнэлгээний зорилгоор хийсвэрээр нэмж үнэлнэ.

Эсхүл

Барааны өндөр хэрэглээний ба өндөр үнэ цэнэ бүхий эд анги болон сэлбэг хэрэгслийн жагсаалтыг үйл ажиллагааны эхний үе шатанд хэрэглэгдэх тоо хэмжээний хамт бэлтгэнэ. Тендерийг үнэлэх зорилгоор эдгээр хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн тоо хэмжээнд харгалзах нийт үнийг тооцоходоо тендерт оролцогчийн ирүүлсэн сэлбэг хэрэгслийн нэгжийн үнийг тендерийн үнэ дээр нэмнэ.

5. **Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах чанар ба үнэлгээний арга (Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад энэхүү үнэлгээний зааврыг тендерийн баримт бичгээс хасна)**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 70 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} —Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн үнэ

P_x —Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x —Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} —Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн оноо

2. Чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

- 2.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо.

- 2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо.

- 2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

- 50 ≤ 60% - 1 оноо;
- 60 ≤ 70% - 2 оноо;
- 70 ≤ 80 % - 3 оноо;
- 80 ≤ 90 % - 4 оноо;
- 90 ≤ 100% - 5 оноо.



2.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортлодог бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

3. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

B_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

6. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлно.

Жишээ нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
I	Нийгмийн шалгуур	Хамгийн их оноо (-5%)
1.1	Олон улсын хөдөлмөрийн стандарт, ОУХБ-ын Суурь конвенцийг дагаж мөрдөж буй байдал	
1.2	Ажиллах хүч / ажил эрхлэлтийн харилцаа	
1.3	Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал	
1.4	Шударга цалин хөлс болон хөдөлмөрийн харилцаа	
1.5	Ажиллах орчны аюулгүй байдал	
1.6	Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ажил эрхлэлт	
II	Эдийн засгийн шалгуур	Хамгийн их оноо (-5%)
2.1	Бизнесийн ёс зүй (Ёс зүйн код)	
2.2	Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дэмжлэг	
2.3	Тээвэрлэлт/хүргэлт	
2.4	Хаяж устгах (Биетээр татан авах эсвэл аюулгүй байдлаар устгах)	
III	Байгаль орчны тогтвортой байдлын шалгуур	Хамгийн их оноо (-10%)
3.1	Байгаль орчны хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал (ISO 14001)	
3.2	Компанийн чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001)	
3.3	Таримал ойгоос бэлтгэсэн, эсхүл дахин боловсруулсан цаас	
3.4	Энгийн хлор агуулаагүй	
3.5	Цайралт	
3.6	Байгаль орчинд ээлтэй савлагаа	
3.7	Дахин боловсруулах боломжтой	

Дээрх үнэлгээний шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тендерт оролцогчийн санал болгож буй үнийг (-20) хувь хүртэл нэмэгдүүлж харьцуулах үнийг тодорхойлно. Уг үнэ нь зөвхөн харьцуулах зорилготой. Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД



Маягт 1	Тендер илгээх маягт	1
Маягт 2	Барааны үнийн задаргаа	2
Маягт 3	Тендерийн баталгаа (банкны)	4
Маягт 4	Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)	5
Маягт 5	Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл	7
Маягт 6	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	7
Маягт 7	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	8

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [тендерт оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.²
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

² Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна." гэж сольж бичнэ үү.

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ³	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ⁴
1										Тийм/Үгүй
2										
...										
Тендерийн нийт үнэ										

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:**

³ ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.
⁴ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "Тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 Тендерийн баталгаа (банкны)

Баталгаа хүлээн авагч: *[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

Огноо: *[баталгаа гаргасан огноог бичих]*

Дугаар: *[тендерийн баталгааны дугаар бичих]*

Баталгаа гаргагч: *[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]*




1. Баталгаа гаргагч нь *[тендерт оролцогчийн нэр]* (цаашид “тендерт оролцогч” гэх)-аас *[тендер шалгаруулалтын нэр, дугаар]* тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн⁵ төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүссэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.]

[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

⁵ Энэ дүн нь ТШЗ-ны 23.1-д заасантай ижил байна.

Маягт 4 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)



Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-ийг **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**⁶ төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валютын төлбөрийн үүрэг хүлээх баталгааг нийт **[мөнгөн дүн]** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр болон холбогдох бусад мэдээллийг бичих]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г⁷ үндэслэн гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

⁶ Энэ дүн нь ТШЗ-ны 23.1-д заасантай ижил байна.


⁷ Засгийн газрын бонд болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг заана уу.]

[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]



Маягт 5 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл



Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 6 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 7

Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл



Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 8

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт



	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

..... дугаар гэрээний 2-р хавсралт

**НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧГИЙН ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

Төсөл арга хэмжээний нэр:

Гэрээний дугаар:



Гэрээний ерөнхий нөхцлийн заалтын дугаар	<i>Тусгай нөхцлийн агуулга</i>
ГЕН 2.2.	Дагалдах үйлчилгээ шаардлагатай эсэх: -“Тийм”, “Үгүй” гэдгээс сонгох
ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: [Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрын хаяг, байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих]
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: <i>[огноо бичих]</i> Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа:<i>[огноо бичих эсхүл нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]</i>
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: [Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих] Бараанд холбогдох баримт бичиг: [бараанд холбогдох ямар баримт бичгүүдийг хүлээлгэж өгөх талаар бичих] Угсралт, суурилуулах: [ямар барааг юунд, хэрхэн угсарч,суурилуулах гэх мэт.]
ГЕН 2.14.	Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих.] [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих] Баглаа, боодлын шаардлага: Жишээ нь: [Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: [Тендерийн баримт бичгийн ТШЗ 20.6-ийн дагуу ТӨХ-д заасан бол Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал: <i>Гэрээний үнэнд тохируулга хийхгүй.</i>
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: <i>[он, сар, өдөр]</i>

	Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.2.	Даатгал: [Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: [Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол Тендерийн баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих, 6 сараас 1 жил хүртэлх хугацааг сонгох]
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа шаардана/ шаардахгүй] Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны дүн: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар бичих]
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: "Тийм" , Алдангийн хувь: Барааг нийлүүлэх эцсийн хугацааг гэрээнд заасан өдрөөс хоцроосон тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: "Тийм" Алдангийн хувь: Нийлүүлэгч барааг хүлээлгэн өгч, бараа нийлүүлэлтэй холбогдох баримт бичгийг захиалагч талд хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 20 хоногийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд энэ хугацаанаас хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлнө.

**НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТААР БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

(Гэрээний маягт нь нийтлэг бараа худалдан авахад зориулагдсан бөгөөд барааны онцлог тохирсон гэрээний нөхцлийг гэрээний маягт, тусгай нөхцөлд тусгах үүргийг захиалагч болон үнэлгээний хороо хариуцна)

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ш.ИДЭРБАЯСГАЛАН

ЗӨВШӨӨРСӨН:

....., ХХК-ИЙН ЗАХИРАЛ
...../



[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг 202.. оны сарын ...-ны дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байх бөгөөд санхүүжилтийг гэрээний 6 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн хуваарийн дагуу олгоно.

1.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

1.2. Санхүүжилтийн нийт дүн:

Үүнээс: 202.. онд санхүүжих дүн:

2. Энэхүү гэрээгээр нийлүүлэх барааг 202... оны ... дугаар сарын ... –ны дотор захиалагч талд хүлээлгэн өгнө..

3. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

4.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;

4.3. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.4. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.5. Гэрээний 3 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй гүйцэтгэлийн баталгаа);

4.6. Гэрээний 4 дүгээр хавсралт (Барааны техникийн тодорхойлолт);

4.7. Гэрээний 5 дугаар хавсралт (Бараа нийлүүлэлтийн хуваарь);

4.8. Гэрээний 6 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);

4.9. Гэрээний 7 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);

4.10. Гэрээний 8 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг⁸);

⁸ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

5. Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

7. Барааны нийлүүлэлт нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

8. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, тендерт заасан барааны техникийн тодорхойлолт болон түүний тоо хэмжээг зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

10. Захиалгч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 8 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

11. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

11.1. Захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл, Иргэний хуулийн 249, 254 дүгээр зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

11.2. Захиалагч талыг төлөөлж гэрээний хэрэгжилтийг удирдах захиалагчийн төлөөлөгчийг гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна.

13.3. Захиалагч нь гэрээний хэрэгжилт, бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан үйл ажиллагаа, хугацаа, барааны чанарт байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

11.4. Нийлүүлэгч талд холбогдох хууль журмыг сахин ханган ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

11.5. Талууд хамтран бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээн авах, хуваарилах, гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагч, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, энэ тухай мэдээллийг www.tender.khs.gov.mn сайт болон холбогдох бусад мэдээллийн хэрэгсэлд тухай бүр нийтэлэх үүргийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагаанд ил тод, шударга байх зарчмыг хангана.



11.6. Хэрэв Нийлүүлэгч техникийн тодорхойлолт, чанар, стандарт хангахгүй бараа, дагалдах үйлчилгээг хүлээлгэн өгөхөөр санал болгосон тохиолдолд нийлүүлэлтийг зогсоох, доголдлыг арилгах мэдэгдлийг нийлүүлэгч талд хүргүүлж, гологдлыг арилгуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

11.7. Бараа нийлүүлэлтийн явцын талаарх санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон захиалагчийн төлөөлөгч албан бичгээр нийлүүлэгчид мэдэгдэнэ.

11.8. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг хугацаанд нийлүүлэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглах материал, хувцас хэрэгсэл зэрэг бараа материал худалдан авахад чанарын баталгаа шаардахгүй.

11.9. Гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу нийлүүлэлтийн хэмжээнд тохируулан үр дүнгээр нь санхүүжүүлж болох бөгөөд гэрээний төлбөрийн 30-аас доошгүй хувийн санхүүжилтийг бараа болон дагалдах үйлчилгээг хүлээн авч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

11.10. Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, түүний гэрээний хэрэгжилтийн явцын мэдээлэл болон гэрээг дүгнэж, барааг, дагалдах үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг, тайланг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тухай бүр ирүүлэх бөгөөд тус газар нь гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад нийтлэх үүрэг хүлээнэ.

11.11. Нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Барааг хүлээн авах, шалгалт, туршилт хийх, экспертийн дүгнэлт гаргуулах (шаардлагатай бол)-тай холбоотой аливаа зардлыг:
- /...../ төгрөг
- Дагалдах үйлчилгээтэй холбогдох магадлашгүй ажил:
- /...../ төгрөг

11.12. Захиалагч нь Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний дагуу Нийлүүлэгчийн хүлээх үүрэг болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн бараа түүний дагалдах үйлчилгээг хүлээн авах, гэрээний төлбөрийн санхүүжилтийн хуваарийн дагуу төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх үүрэг хүлээнэ.


11.13. хэрэв чанарын баталгааны хугацаанд барааны чанар, нийлүүлэлтийн өмнөх хадгалалт, тээвэрлэлтийн явцын гэмтэл согог, дагалдах үйлчилгээний чанаргүй гүйцэтгэлийн улмаас бараанд үүссэн зөрчил, гологдлыг арилгах, хохиролыг нөхөн төлөх мэдэгдлийг Захиалагчаас Нийлүүлэгч талд бичгээр мэдэгдэх ба Нийлүүлэгч нь мэдэгдэл авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор зөрчил, гологдол, чанаргүй гүйцэтгэлийг арилгаагүй тохиолдолд Захиалагч чанарын баталгааны барьцаа хөрөнгөөр гологдлыг арилгах арга хэмжээ авах ба гологдлыг арилгахад барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөс давсан зардлыг нийлүүлэгчээс нэхэмжилж авах эрх эдлэнэ.

11.14. Энэхүү гэрээний үүргийг “хангалттай” хэрэгжүүлсэн нийлүүлэгчийг “ногоон”, “хангалтгүй” хэрэгжүүлсэн Нийлүүлэгчийг “хар” хуудсанд тус тус бүртгэх ба захиалагч нь “хар” хуудсан бүртгэгдсэн этгээдийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандах эрх эдлэнэ.

12. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

12.1. Нийлүүлэгч тал нь Иргэний хуулийн 246, 249, 253, 256 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний

хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.



12.2. Бараанд дагалдах үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тус үйлчилгээг нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон ажиллах хүч, машин тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх ба зайлшгүй шаардлагаар тендерт санал болгоогүй хүний нөөц, машин тоног төхөөрөмж ашиглах бол тэдгээрийг ажиллуулах зөвшөөрлийг захиалагчаас авна.

12.3. Захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтод заасан шалгуур, шаардлагад нийцсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, дагалдах үйлчилгээг нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу захиалагчид хүлээлгэн өгөх, гэрээг дүгнүүлэх, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэлийн баримт бичиг үйлдэх, захиалагчаас шаардсан бусад баримт бичгийг Захиалагчид хүргүүлэх үүргийг тус тус Гүйцэтгэгч хүлээнэ.

12.4. Барааг шалгаж хүлээн авахад шаардлагатай гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, барааны катлоги, ашиглалт, засвар үйлчилгээний заавар, гаалийн бичиг, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан бусад баримт бичиг зэргээс тухайн бараа, дагалдах үйлчилгээнд хамаарах хэсгийг бараатай хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

12.5. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн төлөөлөгчийн гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг тухай бүр хэрэгжүүлж биелэлт үр дүнг захиалагчийн төлөөлөгчид тайлагнана.

12.6. Энэхүү гэрээгээр талууд барааны техникийн тодорхойлолт, дагалдах үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, бараа нийлүүлэх хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зөрүү, гэрээний хүчинтэй хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, барааны үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

12.7. Захиалагч болон олон нийтийн зүгээс барааны нийлүүлэлтийн явц, бараа, дагалдах үйлчилгээний чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, захиалагч эрх бүхий бусад байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр тухай бүр мэдэгдэнэ.

12.8. Хэрэв бараа, дагалдах үйлчилгээний чанараас шалтгаалж бараанд гологдол, гэмтэл үүсвэл чанаргүй барааг шинэ бараагаар солих, чанаргүй бараанаас үүссэн хохиролыг нөхөн төлөх үүргүүдийг Нийлүүлэгч хүлээх бөгөөд захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд зөрчил гологдлыг арилгаж барааг захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

12.9. Нийлүүлэгч нь энэ гэрээний 12.8-д заасан зөрчил, гологдол, эвдрэл, гэмтлийг захиалагчийн заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд тухайн зөрчил гологдлыг чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс гаргахыг захиалагч талд зөвшөөрнө. Хэрэв дээрх зөрчил, гологдлыг арилгахад чанарын баталгааны барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй болж захиалагчаас нэмэлт зардал гарвал хэтэрсэн зардлыг Нийлүүлэгч мөн хариуцна.

12.10. Нийлүүлэгч нь гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг бараа хүлээн авч гэрээ дүгнэсэн тухай мэдэгдэл гарсанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Гэрээний хугацаа дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд эдгээр баталгааг чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

12.11. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэлтийн үе шат бүрийн хэрэгжилтийн явц болон барааг хүлээлгэн өгсөн баримт бичиг, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл, бусад баримт бичиг, фото зургыг www.tender.khs.gov.mn сайтад тухай бүр нийтэлнэ.

13. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

13.1. Нийлүүлэгч нь тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

13.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

13.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

13.4. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Захиргааны ерөнхий хууль", "Иргэний хууль", "Барилгын тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, гэрээний ерөнхий, тусгай нөхцөлд заасан хариуцлагыг хүлээнэ.

13.5. Нийлүүлэгчийн хүсэлт болон түүний гэм буруугийн улмаас гэрээ цуцалсан тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн өмчлөлд үл маргах журмаар Захиалагч талд өгөх үүргийг уг гүйцэтгэлийн баталгааг байршуулсан банк хариуцна.

13.6. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

14. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

14.1. Дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдвол гэрээг цуцалж болно. Үүнд:

14.1.1. талууд энэ гэрээ болон гэрэний ерөнхий тусгай нөхцөлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний ерөнхий нөхцлийн 5.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

14.1.2. Захиалагч, Нийлүүлэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаа дуусгавар болсон,

14.1.3. захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахгүй чанаргүй бараа нийлүүлсэн

14.1.4. Нийлүүлэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн.

14.1.5. гэрээний талууд гэрээний үүргээсээ татгалзсан

14.2. Гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай мэдэгдсэнээс хойш хуанлийн 14 хоногийн дараа гэрээг цуцлах шийдвэр гаргана.

14.3. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

15. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

15.1. Гэрээг 4 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

15.2. Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан "ажил худалдан авах ажиллагаа"-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 4 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

15.3. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

15.4. Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөрчил гологдлыг Гүйцэтгэгч тал харицан арилгаж дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

16. ГЭРЭЭ ДҮГНЭХ

16.1. Захиалагч нь нийлүүлэгч байгууллагатай хамтран барааг хүлээн авах ажиллагааг зохион байгуулж, бараа нийлүүлэх гэрээг дараахь 2 үе шатаар дүгнэнэ: Үүнд:

16.1.1. хүлээн авах комисс ажиллаж гэрээ болон холбогдох хууль, журманд заасан баримт бичгийг хянаж, барааг хүлээн авсны дараа гэрээнд заасан санхүүжилтийг олгоно.

16.1.2. барааны баталгаат засвар (чанарын баталгааны хугацаа) дууссаны дараа гэрээг дүгнэж, чанарын баталгааг чөлөөлж, гүйцэтгэгчид олгоно.

16.1.3. Бараа нийлүүлэлтийн үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг бараа хүлээн авсан акт, гэрээний бусад нөхцлийг үндэслэн захиалагч, гүйцэтгэгч хамтран дүгнэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ


ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА

.....

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар
сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн дөрөв дүгээр хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталж, *Сангийн сайдын 2022 оны 135 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.*

2022 он

**II БҮЛЭГ. ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**




ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>[захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>[төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>[цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]</i>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: багцын нэр, Багц № 2: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих: <i>Дотоодын багц № 3: багцын нэр, Дотоодын багц № 4: багцын нэр...гэх мэт.</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бичих]</i>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <i>[мөнгөн дүн бичих]</i> <i>[Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бичих:</i> <i>Багц №...: _____</i> <i>Багц №...: _____]</i>
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: <i>[хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бичих]</i> Хаяг: <i>[хүсэлт хүлээн авах хаягийг бичих]</i> Утасны дугаар: <i>[албан байгууллагын утасны дугаарыг бичих]</i> Цахим шуудангийн хаяг: <i>[албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бичих]</i>

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

ТШЗ 15.1	<p>Дараах баримт бичгийг үндэслэн тендерт оролцогч, түншлэгчийн ерөнхий нөхцлийг магадлана:</p> <p>1.Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг V бүлгийн Error! Reference source not found.-ийн дагуу ирүүлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэг, маргаанд оролцсон эсэх талаарх Шүүхийн тусгай архивын цахим лавлагаа;</p> <p>3.Тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэрийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим лавлагаа;</p> <p>4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй болохыг нотлох Татварын ерөнхий газрын болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим лавлагаа</p> <p>Дээрх лавлагаа нь холбогдох байгууллагын мэдээллийн цахим сангаас шалгах бөгөөд цаасаар авч ирүүлсэн лавлагааг үнэлгээнд харгалзан үзэхгүй.</p> <p>Жич: Тендерт оролцогч дээрх лавлагааг хэрхэн авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 12.2	<p>Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бичих]</p>
ТШЗ 16.2	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>16.2.1. Хугацаа хэтэрсэн зээл, өр, төлбөртэй эсэх талаарх Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг өөрийн харилцагч банкнаас авч тендерт ирүүлнэ.</p> <p>16.2.2. Сүүлийн 2 жил (2021, 2022 онууд)-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;</p> <p>16.2.3. Сүүлийн 2 жил (2021, 2022 онууд)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх ба тендерт оролцогч (түүний түншлэгчид) нь өөрийн хариуцах үүрэгт ноогдох дүнгээр дээрх үзүүлэлтийг хангаж, тендерт оролцогч ашигтай ажилласан болох нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна.</p> <p>16.2.4. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх хөрөнгө дараах эх үүсвэрүүдийн аль нэг, эсхүл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлогдсон байж болно.. Үүнд:</p> <p>16.2.4.1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкнаас авсан дансны үлдэгдэл/</p> <p>16.2.4.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ.</p>

	16.2.4.3. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;												
ШЗ 16.2.4	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэж бичих. Хэрэв шаардах бол шаардлагатай баримт бичгийг жагсааж бичих]												
ТШЗ 16.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 2 жил (2021, 2022 онууд)-ийн борлуулалтын орлого												
ТШЗ 16.6	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Үүнд: <ul style="list-style-type: none"> - Ижил төстэй гэрээний туршлага:... - Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:... - Нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлт:... 												
ТШЗ 16.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бичих]												
ТШЗ 16.6.2	Барааг өөрөө үйлдвэрлээгүй бол барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт: Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгосон тохиолдолд Захиалагчийн тендерийн баримт бичгийн I бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны ерөнхий зүйлийн ТШЗ 16.6.2 дугаар хэсэгт заасан нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй холбоотой баримт бичгийг ирүүлнэ.												
ТШЗ 16.6.3	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: ["Шаардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Барааг ашиглахын тулд суурилуулах, турших, тохируулах, хүний нөөцийг сургах зэрэг үйлчилгээ авах тохиолдолд "Шаардана" гэж сонгож уг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих] <p>1. Захиалагч хүний нөөцийн мэдээлэл шаардсан тохиолдолд уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг дор дурьдсан хүснэгтээр ирүүлнэ.</p> <table border="1" data-bbox="462 1675 1395 1836"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүн ий Тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td>Диплом ирүүлэх шаардлагагүй.</td> </tr> </tbody> </table> <p>2. Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.</p>	№	Албан тушаал	Хүн ий Тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх						Диплом ирүүлэх шаардлагагүй.
№	Албан тушаал	Хүн ий Тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх								
					Диплом ирүүлэх шаардлагагүй.								

	<p>3. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>4. Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээний мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. Ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p> <p>5. Төсөлд санал болгосон ажилтан, ажилчид нь гадаад улсын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас татсан файлыг тендерт ирүүлнэ.</p> <p>6. Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, ажилчдад хамаарахгүй инженер, техникийн ажилтан, ажилчдыг төсөлд санал болгосон бол тэдэнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.</p> <p>7. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давах ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 16.6.4	<p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл:</p> <p>1. Сүүлийн 5 жилд энэхүү тендерээр худалдан авах бараатай иж төстэй бараа нийлүүлсэн туршлагад хамаарах гэрээний мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 3, маягт 4, Маягт 5 хүснэгтүүдэд заасан өгөгдлийн дагуу ирүүлнэ.</p> <p>2. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Үүнд:</p> <p>2.1. Сүүлийн 5 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон бараа түүнтэй ижил төстэй барааны нэрийг бичих/..... барааг нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. Энэхүү тендерийн дагуу нийлүүлэх төсөл арга хэмжээ (багц)-нд хамаарах бараатай дүйцэхүйц зориулалт, шинж чанар, зориулалт бүхий барааны нийлүүлэлтийг ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагад тооцно.</p> <p>2.2. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагад тооцуулах гэрээтэй холбоотой дараах мэдээллийг тендерт ирүүлнэ.</p> <p>2.2.1. Барааг нийлүүлэхээр захиалагчтай байгуулсан гэрээ</p> <p>2.2.2. Барааг хүлээн авсан акт,</p> <p>2.2.3. Захиалагчтай байгуулсан гэрээг дүгнэсэн акт,</p> <p>2.2.4. Ижил төстэй бараа нийлүүлэлтэд тооцуулахаар санал болгосон барааг гэрээний хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх өмнөх</p>



захиалагчийн тодорхойлолтыг дор дурьдсан байгууллагуудаас ирүүлснийг үнэлгээнд харгалзан үзнэ.

2.2.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.3, 45.4 дэх хэсгүүдэд заасан захиалагч байгууллага,

2.2.4.2. Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд

ТШЗ 16.6.5 Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **["Шардана" эсхүл "Шаардахгүй" гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв тэсрэх бодис, шингэн болон хийн төлөвт байгаа нефтийн бүтээгдэхүүн, тусгай зориулалтын машин механизм, зэрэг барааг тээвэртэй нийлүүлэлтээр худалдан авахаас бусад тохиолдолд тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж шаардахгүй.]**

Энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг шаардлагатай гэж сонгосон бол тендерт оролцогч тэдгээрийг доорх хүснэгтэд заасан зориулалт, шалгуур, шаардлагад нийцүүлэн санал болгоно.

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар	Эзэмшигчийн мэдээлэл

2. Бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэн ашиглах тохиолдолд Монгол улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг нийцэхүйц /хөлслөх/ гэрээг төсөл хэрэгжих хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулсан байна.

3. Дээрх хүснэгтээр санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжүүдийн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх байх шаардлагатай.

4. Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, холбогдох мэдээллийг тендерт ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой лавлага, бусад мэдээллийг цахим системээс шалгана.

5. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.

ТШЗ 16.6.6 Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: **"Шардана"**

- Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг захиалагчийн тендерийн баримт бичгийн III бүлгийн 3 дугаар хуудсанд заасан "техникийн тодорхойлолт" маягтад харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хэлбэрээр бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ.
- Барааны үнийн задаргааг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн Маягт 2 хүснэгтээр бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ.

	<p>3. Бараа нийлүүлэлтийн хуваарийг захиалагчийн тендерийн баримт бичгийн III бүлгийн 4 дүгээр хуудсанд заасан "бараа нийлүүлэлтийн хуваарь" маягтад заасан мэдээллийн дагуу бэлтгэн баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>4. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>5. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>6. Бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтыг нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, стандарт, катлогийн дугаар хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн үнэн зөвөөр харьцуулсан тайлбар, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарт дурдсан байна.</p>
<p>ТШЗ 17</p>	<p>Санал болгосон бараа тендерийн баримт бичигт нийцсэнийг нотлох баримт бичиг:</p> <p>17.1.Барааны гарал үүсэлийн мэдээлэл ирүүлэх: "Шаардлагатай"</p> <p>17.1.1.Нийлүүлэхээр санал болгосон бараа нь Захиалагчийн тендерийн баримт бичгийн I бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны ерөнхий зүйлийн ТШЗ-ны 7 дугаар зүйлд заасан гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.</p> <p>17.1.2.Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>17.2. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.</p> <p>17.3.Санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтыг хангаж буйг нотлох баримт шаардах эсэх: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв захиалагч шаардана гэж сонговол тендерт оролцогч барааны загвар дээжийг ирүүлнэ.]</p> <p>17.4. Бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтыг нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, стандарт, катлогийн дугаар хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн үнэн зөвөөр харьцуулсан тайлбар, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарт дурдсан байна.</p> <p>17.6.Тендерт оролцогчид давуу эрх олгох: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</p>

	<p>хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бөгөөд түүнийг ирүүлсэн тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй барааны хэсгийн үнийг 10 хувиар хийсвэрээр бууруулж бусад оролцогчийн ирүүлсэн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч давуу эрх тооцуулах бол дараах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.1. Ажилд ашиглах материал бүтээц хийцийн гарал үүсэл, үнэ өртгийн талаарх мэдээлэл,</p> <p>2.2. Хуулийн 10 дугаар зүйлийн дагуу давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичиг.</p> <p>2.3. Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт</p>
ТШЗ 18.6	<p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Туйм”</p> <p>Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 21.4	<p>Тендерийг баталгаажуулах, илгээх: Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 24.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p>
ТШЗ 21.5.3	<p>Тендерт оролцогч ТШЗ 21.7-д зааснаас бусад ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага; 2. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ 3. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага; 4. Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл 5. Барааг дамжуулан борлуулах зөвшөөрөл; 6. Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл; 7. Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл; 8. Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт; 9. Тендерт оролцогч түншлэгч, туслан гүйцэтгэгчийн мэдээлэл 10. Тендерт оролцогчид давуу эрх олгохтой холбоотой баримт бичиг Санал болгосон бараа тендерийн баримт бичигт нийцснийг нотлох баримт бичиг: ТШЗ 17-д заасан баримт бичиг
ТШЗ 21.7	<p>Нууцлах баримт бичиг: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн</p>

ТШЗ 21.7	<p>Нууцлах баримт бичиг: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p>
ТШЗ 22.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бичих]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бичих]</p>
ТШЗ 24.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бичих. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бичих. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</p> <p>Тендер нээх газрын хаяг: [аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</p>
ТШЗ 28.2	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]</p> <p>Хэрэв "Ашиглах" бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</p>
Д. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 35.1 Мэдэгдэл хүргэсэнд тооцох	<p>Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн V бүлгийн жишиг маягтуудын МАЯГТ 1 буюу тендер илгээх маягтад зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.</p>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.


Шалгалт, туршилт

[Захиалагч тендер оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендер оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад

тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]




ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичих)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулна.]



Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендэрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Тендэрт оролцогч энэ баганыг бөглөнө)
1				5	6	7
1	[Барааны нэрийг бичих]	[нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бичих. Жишээ нь: 2020.10.01-ээс 2020.10.14]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2						
3						
...						

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 32.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]**

Хэрэв "ашиглах" бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бич]**-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас **[тоо бич]**-аас илүү **["сар", "өдөр" гэдэг үгнээс сонгож бич]** хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]**

Хэрэв "ашиглах" бол тендерт санал болгосон барааны **[тоо бич]** **["сар", "өдөр", "жил" гэдэг үгнээс сонгож бич]** хугацаанд шаардагдах урсгал зардлын хэмжээг тооцоолж ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

Мөн тендерийн дагуу санал болгосон барааны үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлж болно.

3. Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич.]**

Хэрэв "ашиглах" бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

4. Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшгүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: **["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бич]**

Ашиглалтын эхний хугацааны дотор шаардагдаж болох гол эд анги, бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээний жагсаалтыг барааны жагсаалтанд оруулсан байна. Ингэхдээ гол эд анги бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн үнийг тендерийн үнээс тусад нь ирүүлэх ёстой. Тендер бүрийн үнийн саналд дурдсан нэгж үнэд тулгуурлан дээрх жагсаалтанд орсон эд зүйлсийн нийт үнийг тендерийн үнэ дээр үнэлгээний зорилгоор хийсвэрээр нэмж үнэлнэ.

Эсхүл

Барааны өндөр хэрэглээний ба өндөр үнэ цэнэ бүхий эд анги болон сэлбэг хэрэгслийн жагсаалтыг үйл ажиллагааны эхний үе шатанд хэрэглэгдэх тоо хэмжээний хамт бэлтгэнэ. Тендерийг үнэлэх зорилгоор эдгээр хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн тоо хэмжээнд харгалзах нийт үнийг тооцохдоо тендерт оролцогчийн ирүүлсэн сэлбэг хэрэгслийн нэгжийн үнийг тендерийн үнэ дээр нэмнэ.

5. **Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах чанар ба үнэлгээний арга (Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад энэхүү үнэлгээний зааврыг тендерийн баримт бичгээс хасна)**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 70 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн үнэ

P_x – Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x – Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн оноо

2. Чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.
- 2.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:
- Тухайн багцын:
- $0 \leq 50\%$ - 0 оноо;
 - $50 \leq 60\%$ - 1 оноо;
 - $60 \leq 70\%$ - 2 оноо;
 - $70 \leq 80\%$ - 3 оноо;
 - $80 \leq 90\%$ - 4 оноо;
 - $90 \leq 100\%$ - 5 оноо.
- 2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):
- Тухайн багцын:
- $0 \leq 50\%$ - 0 оноо;
 - $50 \leq 60\%$ - 1 оноо;
 - $60 \leq 70\%$ - 2 оноо;
 - $70 \leq 80\%$ - 3 оноо;
 - $80 \leq 90\%$ - 4 оноо;
 - $90 \leq 100\%$ - 5 оноо.
- 2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:
- Тухайн багцын:
- $0 \leq 50\%$ - 0 оноо;

- 50 ≤ 60% - 1 оноо;
- 60 ≤ 70% - 2 оноо;
- 70 ≤ 80 % - 3 оноо;
- 80 ≤ 90 % - 4 оноо;
- 90 ≤ 100% - 5 оноо.



2.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортлодог бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо.

3. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

B_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

6. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.


[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлно.

Жишээ нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
I	Нийгмийн шалгуур	Хамгийн их оноо (-5%)
1.1	Олон улсын хөдөлмөрийн стандарт, ОУХБ-ын Суурь конвенцийг дагаж мөрдөж буй байдал	
1.2	Ажиллах хүч / ажил эрхлэлтийн харилцаа	
1.3	Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал	
1.4	Шударга цалин хөлс болон хөдөлмөрийн харилцаа	
1.5	Ажиллах орчны аюулгүй байдал	
1.6	Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ажил эрхлэлт	
II	Эдийн засгийн шалгуур	Хамгийн их оноо (-5%)
2.1	Бизнесийн ёс зүй (Ёс зүйн код)	
2.2	Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дэмжлэг	
2.3	Тээвэрлэлт/хүргэлт	
2.4	Хаяж устгах (Биетээр татан авах эсвэл аюулгүй байдлаар устгах)	
III	Байгаль орчны тогтвортой байдлын шалгуур	Хамгийн их оноо (-10%)
3.1	Байгаль орчны хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал (ISO 14001)	
3.2	Компанийн чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001)	
3.3	Таримал ойгоос бэлтгэсэн, эсхүл дахин боловсруулсан цаас	
3.4	Энгийн хлор агуулаагүй	
3.5	Цайралт	
3.6	Байгаль орчинд ээлтэй савлагаа	
3.7	Дахин боловсруулах боломжтой	

Дээрх үнэлгээний шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тендерт оролцогчийн санал болгож буй үнийг (-20) хувь хүртэл нэмэгдүүлж харьцуулах үнийг тодорхойлно. Уг үнэ нь зөвхөн харьцуулах зорилготой. Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД



Маягт 1	Тендер илгээх маягт.....	2
Маягт 2	Барааны үнийн задаргаа	3
Маягт 3	Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл	4
Маягт 4	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	5

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-ын нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 15.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 15.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ¹	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ²
1										Тийм/Үгүй
2										
...										
Тендерийн нийт үнэ										

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгоогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:**

¹ ТШЗ-ны 16.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.
² Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "Тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл



Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/


Маягт 4**Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 5

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт



	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

Төсөл арга хэмжээний нэр:

Гэрээний дугаар:



ГЕН 2.1.	Бараа нийлүүлэх хугацаа: <i>Бараа нийлүүлэх хугацаа: [огноо бичих]</i> <i>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: [огноо бичих]</i> [Нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]
ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: [Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрын хаяг байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих.]
ГЕН 2.6.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: [Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих] Жишээ нь: Бараанд холбогдох баримт бичиг: [бараанд холбогдох ямар баримт бичгүүдийг хүлээлгэж өгөх талаар бичих] Угсралт, суурлуулах: [ямар барааг юунд хэрхэн угсарч, суурьлуулах] гэх мэт.
ГЕН 2.10.	Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих] [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.] Баглаа, боодлын шаардлага: Жишээ нь: [Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]
ГЕН 2.13.	Худалдааны нөхцөл: [Тендерийн баримт бичгийн ТӨХ-д заасан бол ТШЗ 18.6-д заасан Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд, Төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.2.	Даатгал: [Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрлийг тодорхой бичих]

ГЕН 4.10.	Чанарын баталгаат хугацаа: <i>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол Тендерийн баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих, 6 сараас 1 жил хүртэлх хугацааг сонгох]</i>
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <i>[Чанарын баталгаа шаардана/шаардахгүй]</i> Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны дүн: <i>[Гэрээний үнийн дүнгийн 5-10 хооронд сонгох]</i>
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алдангийн хувь: : <i>Барааг нийлүүлэх эцсийн хугацааг гэрээнд заасан өдрөөс хоцроосон тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.</i>
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алдангийн хувь: Алдангийн хувь: <i>Нийлүүлэгч барааг хүлээлгэн өгч, бараа нийлүүлэлтэй холбогдох баримт бичгийг захиалагч талд хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 20 хоногийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд энэ хугацаанаас хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлнө.</i>

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
ХУДАЛДАН АВАХ ҮЕД ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

(Гэрээний маягт нь нийтлэг бараа худалдан авахад зориулагдсан бөгөөд барааны онцлогт тохирсон гэрээний нөхцлийг гэрээний маягт, тусгай нөхцөлд тусгах үүргийг захиалагч болон үнэлгээний хороо хариуцна)

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ш.ИДЭРБАЯСГАЛАН

ЗӨВШӨӨРСӨН:

....., ХХК-ИЙН ЗАХИРАЛ
...../



**[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг 202.. оны сарын ...-ны дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байх бөгөөд санхүүжилтийг гэрээний 6 дугаар хавсралтад заасан санхүүжилтийн хуваарийн дагуу олгоно.

1.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

1.2. Санхүүжилтийн нийт дүн:

Үүнээс: 202.. онд санхүүжих дүн:

2. Энэхүү гэрээгээр нийлүүлэх барааг 202... оны ... дугаар сарын ... –ны дотор захиалагч талд хүлээлгэн өгнө..

3. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

4.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;

4.3. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.4. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.5. Гэрээний 4 дүгээр хавсралт (Барааны техникийн тодорхойлолт);

4.6. Гэрээний 5 дугаар хавсралт (Бараа нийлүүлэлтийн хуваарь);

4.7. Гэрээний 6 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);

4.8. Гэрээний 7 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан дугаартай

.... төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);

4.9. Гэрээний 8 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг³);

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд



4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

5. Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

7. Барааны нийлүүлэлт нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

8. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, тендерт заасан барааны техникийн тодорхойлолт болон түүний тоо хэмжээг зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

10. Захиалгч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 8 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

11. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

11.1. Захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл, Иргэний хуулийн 249, 254 дүгээр зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

11.2. Захиалагч талыг төлөөлж гэрээний хэрэгжилтийг удирдах захиалагчийн төлөөлөгчийг гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна.

11.3. Захиалагч нь гэрээний хэрэгжилт, бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан үйл ажиллагаа, хугацаа, барааны чанарт байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

11.4. Нийлүүлэгч талд холбогдох хууль журмыг сахин ханган ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

11.5. Талууд хамтран бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээн авах, хуваарилах, гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагч, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, энэ тухай мэдээллийг www.tender.khs.gov.mn сайт болон холбогдох бусад мэдээллийн хэрэгсэлд тухай бүр нийтэлэх үүргийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагаанд ил тод, шударга байх зарчмыг хангана.

11.6. Хэрэв Нийлүүлэгч техникийн тодорхойлолт, чанар, стандарт хангахгүй бараа, дагалдах үйлчилгээг хүлээлгэн өгөхөөр санал болгосон тохиолдолд нийлүүлэлтийг зогсоох, доголдлыг арилгах мэдэгдлийг нийлүүлэгч талд хүргүүлж, гологдлыг арилгуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

11.7. Бараа нийлүүлэлтийн явцын талаарх санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон захиалагчийн төлөөлөгч албан бичгээр нийлүүлэгчид мэдэгдэнэ.

11.8. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг хугацаанд нийлүүлэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглах материал, хувцас хэрэгсэл зэрэг бараа материал худалдан авахад чанарын баталгаа шаардахгүй.

11.9. Гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу нийлүүлэлтийн хэмжээнд тохируулан үр дүнгээр нь санхүүжүүлж болох бөгөөд гэрээний төлбөрийн 30-аас доошгүй хувийн санхүүжилтийг бараа болон дагалдах үйлчилгээг хүлээн авч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

11.10. Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, түүний гэрээний хэрэгжилтийн явцын мэдээлэл болон гэрээг дүгнэж, барааг, дагалдах үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг, тайланг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тухай бүр ирүүлэх бөгөөд тус газар нь гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад нийтлэх үүрэг хүлээнэ.

11.11. Нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Барааг хүлээн авах, шалгалт, туршилт хийх, экспертийн дүгнэлт гаргуулах (шаардлагатай бол)-тай холбоотой аливаа зардлыг:
- /...../ төгрөг
- Дагалдах үйлчилгээтэй холбогдох магадлашгүй ажил:
- /...../ төгрөг

11.12. Захиалагч нь Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний дагуу Нийлүүлэгчийн хүлээх үүрэг болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн бараа түүний дагалдах үйлчилгээг хүлээн авах, гэрээний төлбөрийн санхүүжилтийн хуваарийн дагуу төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх үүрэг хүлээнэ.

11.13. Хэрэв чанарын баталгааны хугацаанд барааны чанар, нийлүүлэлтийн өмнөх хадгалалт, тээвэрлэлтийн явцын гэмтэл согог, дагалдах үйлчилгээний чанаргүй гүйцэтгэлийн улмаас бараанд үүссэн зөрчил, гологдлыг арилгах, хохиролыг нөхөн төлөх мэдэгдлийг Захиалагчаас Нийлүүлэгч талд бичгээр мэдэгдэх ба Нийлүүлэгч нь мэдэгдэл авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор зөрчил, гологдол, чанаргүй гүйцэтгэлийг арилгаагүй тохиолдолд Захиалагч чанарын баталгааны барьцаа хөрөнгөөр гологдлыг арилгах арга хэмжээ авах ба гологдлыг арилгахад барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөс давсан зардлыг нийлүүлэгчээс нэхэмжилж авах эрх эдлэнэ.

11.14. Энэхүү гэрээний үүргийг “хангалттай” хэрэгжүүлсэн нийлүүлэгчийг “ногоон”, “хангалтгүй” хэрэгжүүлсэн Нийлүүлэгчийг “хар” хуудсанд тус тус бүртгэх ба захиалагч нь “хар” хуудсан бүртгэгдсэн этгээдийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандах эрх эдэлнэ.

12. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

12.1. Нийлүүлэгч тал нь Иргэний хуулийн 246, 249, 253, 256 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

12.2. Бараанд дагалдах үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тус үйлчилгээг нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон ажиллах хүч, машин тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх ба зайлшгүй шаардлагаар тендерт санал болгоогүй хүний нөөц, машин тоног төхөөрөмж ашиглах бол тэдгээрийг ажиллуулах зөвшөөрлийг захиалагчаас авна.

12.3. Захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтод заасан шалгуур, шаардлагад нийцсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, дагалдах үйлчилгээг нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу захиалагчид хүлээлгэн өгөх, гэрээг дүгнүүлэх, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэлийн баримт бичиг үйлдэх, захиалагчаас шаардсан бусад баримт бичгийг Захиалагчид хүргүүлэх үүргийг тус тус Гүйцэтгэгч хүлээнэ.

12.4. Барааг шалгаж хүлээн авахад шаардлагатай гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, барааны катлоги, ашиглалт, засвар үйлчилгээний заавар, гаалийн бичиг, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан бусад баримт бичиг зэргээс тухайн бараа, дагалдах үйлчилгээнд хамаарах хэсгийг бараатай хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

12.5. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн төлөөлөгчийн гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг тухай бүр хэрэгжүүлж биелэлт үр дүнг захиалагчийн төлөөлөгчид тайлагнана.

12.6. Энэхүү гэрээгээр талууд барааны техникийн тодорхойлолт, дагалдах үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, бараа нийлүүлэх хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зөрүү, гэрээний хүчинтэй хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, барааны үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

12.7. Захиалагч болон олон нийтийн зүгээс барааны нийлүүлэлтийн явц, бараа, дагалдах үйлчилгээний чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, захиалагч эрх бүхий бусад байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр тухай бүр мэдэгдэнэ.

12.8. Хэрэв бараа, дагалдах үйлчилгээний чанараас шалтгаалж бараанд гологдол, гэмтэл үүсвэл чанаргүй барааг шинэ бараагаар солих, чанаргүй бараанаас үүссэн хохиролыг нөхөн төлөх үүргүүдийг Нийлүүлэгч хүлээх бөгөөд захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд зөрчил гологдлыг арилгаж барааг захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

12.9. Нийлүүлэгч нь энэ гэрээний 12.8-д заасан зөрчил, гологдол, эвдрэл, гэмтлийг захиалагчийн заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд тухайн зөрчил гологдлыг чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс гаргахыг захиалагч талд зөвшөөрнө. Хэрэв дээрх зөрчил, гологдолыг арилгахад чанарын баталгааны барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй болж захиалагчаас нэмэлт зардал гарвал хэтэрсэн зардлыг Нийлүүлэгч мөн хариуцна.

12.10. Нийлүүлэгч нь гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг бараа хүлээн авч гэрээ дүгнэсэн тухай мэдэгдэл гарсанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Гэрээний хугацаа дуусаагүй тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгааг чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

12.11. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэлтийн үе шат бүрийн хэрэгжилтийн явц болон барааг хүлээлгэн өгсөн баримт бичиг, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл, бусад баримт бичиг, фото зургыг www.tender.khs.gov.mn сайтад тухай бүр нийтэлнэ.

13. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

13.1. Нийлүүлэгч нь тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

13.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

13.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

13.4. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Иргэний хууль”, “Барилгын тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, гэрээний ерөнхий, тусгай нөхцөлд заасан хариуцлагыг хүлээнэ.

13.5. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

14. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

14.1. Дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдвол гэрээг цуцалж болно. Үүнд:

14.1.1. талууд энэ гэрээ болон гэрээний ерөнхий тусгай нөхцөлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний ерөнхий нөхцлийн 5.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

14.1.2. Захиалагч, Нийлүүлэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаа дуусгавар болсон,

14.1.3. захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахгүй чанаргүй бараа нийлүүлсэн

14.1.4. Нийлүүлэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн.

14.1.5. гэрээний талууд гэрээний үүргээсээ татгалзсан

14.2. Гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай мэдэгдсэнээс хойш хуанлийн 14 хоногийн дараа гэрээг цуцлах шийдвэр гаргана.

14.3. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

15. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

15.1. Гэрээг 4 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

15.2. Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн 145 дугаар тушаалын хавсралтаар баталсан “ажил худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл,

гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 4 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

15.3. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

15.4. Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөрчил гологдлыг Гүйцэтгэгч тал харицан арилгаж дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.



16. ГЭРЭЭ ДҮГНЭХ

16.1. Захиалагч нь нийлүүлэгч байгууллагатай хамтран барааг хүлээн авах ажиллагааг зохион байгуулж, бараа нийлүүлэх гэрээг дараахь 2 үе шатаар дүгнэнэ: Үүнд:

16.1.1. хүлээн авах комисс ажиллаж гэрээ болон холбогдох хууль, журманд заасан баримт бичгийг хянаж, барааг хүлээн авсны дараа гэрээнд заасан санхүүжилтийг олгоно.

16.1.2. барааны баталгаат засвар (чанарын баталгааны хугацаа) дууссаны дараа гэрээг дүгнэж, чанарын баталгааг чөлөөлж, гүйцэтгэгчид олгоно.

16.1.3. Бараа нийлүүлэлтийн үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг бараа хүлээн авсан акт, гэрээний бусад нөхцлийг үндэслэн захиалагч, гүйцэтгэгч хамтран дүгнэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

.....
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

Аймгийн Засаг даргын 2022 оны 12
дугаар сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн тав дугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**


Сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан, Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.

2022 он

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧГИЙН ТЕНДЕРИЙН ӨГӨГДӨЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

Төслийн нэр:

Тендер шалгаруулалтын дугаар:



ТӨХ-ын холбогдох заалт	Ерөнхий зүйл
ТӨЗ 1.1	Захиалагч нь: <i>Хөвсгөл аймгийн Засаг дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газар</i>
	Үнэлгээний арга:
ТӨЗ 1.2	Техникийн болон санхүүгийн саналаа нэгэн зэрэг ирүүлэх
ТӨЗ 1.3	Зөвлөх үйлчилгээ үе шатад хуваагдана: [“тийм” эсхүл “үгүй” гэсний аль тохирохыг сонгож үлдээ. Хэрэв тийм бол үе шатыг заа]
ТӨЗ 1.4.	Санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулагдана: [тийм эсхүл үгүй аль тохирохыг сонгох. Хэрэв тийм бол уулзалт болох газар, огноо, цагийг заа] Мөн захиалагчийн ажилтны нэр, хаяг болон утасны дугаар:
ТӨЗ 1.5	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж: 1. Захиалагч нь зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөхтэй гэрээний асуудлаар харилцах захиалагчийн төлөөлөгчийг томилох , 2. Эскиз зураг, төслийг хянаж баталгаажуулах 3. Ажлын өртгийн төсвийг хянаж зөвшөөрөх эсэх шийдвэр гаргах 4. Эрх бүхий байгууллагад хандан зураг төсөл, өртгийн төсөвт магадлал, хянан баталгаа хийлгэх хүсэлт хүргүүлэх. 4. Баталгаажсан зураг төслийг хянан хүлээн авч, зөвлөхтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний санхүүжилтийг олгох үйл ажиллагааг зохион байгуулна.
ТӨЗ 1.7.2	Зөвлөх үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай: “тийм” эсвэл “үгүй” [хэрэв тийм бол ажлын даалгаварт цаашид гүйцэтгэх ажлын хэмжээ, онцлог, хугацаа болон энэ мэдээллийг үнэлгээнд хэрхэн харгалзахыг зааж өгнө.]
ТӨЗ 1.11	Зөвлөх (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна) нь эрх бүхий болохоо нотолж дараах баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд: 1.11.1. Зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд: • • Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь тус тус зөвлөх үйлчилгээг дуусган захиалагчид хүлээлгэн өгөх өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. 1.11.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4, 14.1.6 дахь хэсэгт заасан нөхцлүүд тогтоогдсон эсэх тухай шүүхийн тусгай архивын цахим лавлагааг ирүүлнэ. (Тендерт оролцогч Худалдан

	<p>авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу)</p> <p>1.11.3. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн эсэх, өр төлбөртэй эсэхийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем" www.tender.gov.mn болон "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p>1.11.4.Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгааны 1.11.1-1.11.11-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.Салбарын зарим яамдаас олгодог тусгай зөвшөөрөлийн мэдээлэл цахим системд нэгдсэн журмаар ороогүй байгаа тул энэ ангилалд хамаарах тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерт ирүүлнэ.</p>
ТӨЗ 2.1	Санал хүлээн авах хугацаанаас 5 хоногийн өмнө ирсэн тодруулгад хариу өгнө. [тодруулга хүлээн авах хаягыг оруул.]
ТӨЗ 3.3	Тендерийн баталгааны үнийн дүн: [Төсөвт өртгийн 0,5 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулна.]
ТӨЗ 3.5	Хүчинтэй байх хугацаа: он сар өдөр [Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг он, сар, өдрөөр тогтооно]
ТӨЗ 4.1	Саналыг хэл (хэлүүд)-ээр ирүүлнэ.
ТӨЗ 4.4	Хураангуй жагсаалтад орсон компани мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: "тийм" эсхүл "үгүй" Хамтран ажиллах тохиолдолд түншлэл,туслан гүйцэтгэгч
ТӨЗ 4.4.1	Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд ___ хүн-сар мэргэжлийн үйлчилгээ шаардагдана. Зөвлөх үйлчилгээгонысарын ...-ны өдрөөс өмнө захиалагчид хүлээлгэн өгнө.
ТӨЗ 4.4.2	Чанарын үнэлгээний аргыг хэрэглэх бол тухайн зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг: (Тендерт оролцогч нь төсөвт өртөгийг тооцож ирүүлнэ)

ТӨЗ 4.4.4

Зөвлөхийн санал болгох ажилтны мэргэжил, туршлагыг дараах хүснэгтэд зааснаар ирүүлнэ: (Тусгай зөвшөрөлд шаардсан мэргэжлийн инженер техникийн ажилтныг ирүүлэхээр шаардана)

1. Ажилллах хүчний мэдээлэл:

Албан тушаал	Мэргэжил	Нарийн мэргэшсэн туршлага	Ажилтны тоо	Мэргэжлээр ажилласан жилийн тоо

2. Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.

3. Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.

4. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.

5. Хэрэв гадаад улсын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн этгээдийг төсөл арга хэмжээнд ажиллуулахаар санал болгох тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас татсан файлыг тендерт ирүүлнэ.

6. Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, ажилчдад хамаарахгүй инженер, техникийн ажилтан, ажилчдыг төсөлд санал болгосон бол тэдэнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.

7. Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.

8. Дээрх хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх шаардлагатай. Тендерт оролцогч нь үндсэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг тендер нээгдэх өдрөөс өмнөх 3 сард тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул нийгмийн даатгалын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс нийгмийн даатгал төлсөн эсэх мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>

ТӨЗ 4.4.6

Зөвлөхийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг

..... хэл (хэлүүд)-ээр бэлтгэнэ.

Хийгдэх ажлын үндсэн хэсэгт сургалт орсон: тийм, үгүй аль нэгийг сонгох [тийм бол холбогдох мэдээллийг бич]

<p>ТӨЗ 4.5</p>	<p>Техникийн санал ирүүлэх хэлбэр нь: [БХТС эсхүл ХТС аль тохирохыг сонгох] байна.</p> <p>4.5.Тендерт оролцогч болон түүний түншлэгч нь техникийн чадавхийн дор дурьдсан шалгуур шаардлагыг хангасан байна.</p> <p>4.5.1. Сүүлийн 2 жил буюу 2021 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>4.5.2.Сүүлийн 2 жилийн буюу 2021, 2022 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тухайн батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.</p> <p>4.5.3.Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа тухайн батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүн бүхий энэ гэрээтэй ижил төстэй зөвлөх үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>4.5.4. Ижил төстэй үйлчилгээ хэрэгжүүлсэн туршлагад тооцуулахаар санал болгосон зөвлөх үйлчилгээний гэрээ, зураг төсөлд өгсөн магадлалын дүгнэлт, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>4.5.5.Зөвлөх компаний танилцуулга, ижил төстэй ажлын туршлагын мэдээллийг Маягт 3.2 маягтаар ирүүлнэ. Үүнд: санал болгосон ажилтнуудын танилцуулга, хийгдсэн ажлын хугацаа, гэрээний дүн болон тухайн компаний оролцсон байдлыг өмнө хийгдсэн ажил тус бүрээр харуулна.</p> <p>4.5.6.Одоо хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан зөвлөх үйлчилгээний гэрээтэй холбоотой мэдээлэл ирүүлнэ. Энэхүү тендерээр хэрэгжих гэрээтэй давхцан хэрэгжих гэрээний гүйцэтгэл нь 70%-д хүрээгүй тохиолдолд зөвлөхийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно. Иймд давхцан хэрэгжих гэрээний гүйцэтгэл 70 ба түүнээс хувийн хэрэгжилттэй байгаа талаар захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>4.5.7.БХТС-ын хувьд: Төсөл арга хэмжээний чанар/үр нөлөөг сайжруулах талаар ажлын даалгаварт өгөх ажил хэрэгч санал, зөвлөмж болон зөвлөхийн зүгээс гарган өгч болох өгөгдөл, үйлчилгээний жагсаалт болон ажлын байр техник хэрэгслийн талаарх аливаа санал, (Маягт 3.3). б/ ХТС-ын хувьд: Маягт 3.3-ыг бөглөхгүй санал, зөвлөмж гаргах бол ажлын аргачлалтай нэгтгэн ирүүлнэ.</p> <p>4.5.8. БХТС болон ХТС-ын хувьд: Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга (Маягт 3.4). ХТС-ын хувьд: Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж байгаа бол эдгээр нь ерөнхийдөө 10 хуудаст багтсан байна.</p> <p>4.5.9.Ажиллах багийн бүрэлдэхүүн, багийн гишүүн тус бүрийн мэргэжил, хариуцах ажил болон түүнийг хэрэгжүүлэх хугацаа (Маягт 3.5).</p> <p>4.5.10.Санал болгож буй мэргэжлтний намтар. Намтар нь тухайн мэргэжилтэн болон санал ирүүлж буй эрх бүхий этгээдээр гарын үсэг зурагдсан байх бөгөөд тухайн байгууллагад ажилласан жил, сүүлийн 10 жилийн хугацаанд түүний хариуцаж байсан ажил, албан тушаалын талаарх мэдээллийг агуулсан байна (Маягт 3.6).</p> <p>4.5.11.Ажилтны (мэргэжлийн болон туслах ажилтан, хүн-цагаар) ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай оролцоог харуулсан тооцоог хүн тус бүрээр харуулсан хугацааны хуваарийн хамт (Маягт 3.7, 3.8).</p> <p>4.5.12.БХТС-ын хувьд: Санал болгож буй аргачлал, багийн бүрэлдэхүүн, сургалтын (ТӨХэд хийгдэх ажлын нэг гол хэсэг гэж заасан бол) зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга.</p> <p>4.5.13. Тендерт оролцогч нь туслан зөвлөх болон түншлэл</p>
-----------------------	--

	ажиллуулахаар санал болгосон тохиолдолд төлөөлөх эрх бүхий этгээд болон туслан гүйцэтгэгч, түншлэгч нь төрийн худалдан авах авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.
ТӨЗ 4.7	Зөвлөх нь санхүүгийн санлыг дараах байдлаар бэлтгэн ирүүлнэ. Үүнд: 4.7.1. Санхүүгийн саналыг зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийн зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгааны 4.7-д заасан нөхцөл, шаардлагын дагуу 4 дүгээр бүлэгт заасан (4.1- санхүүгийн санал ирүүлэх маягт, 4.2- зардлын товчоо, 4.3- үйл ажиллагаа бүрийн үнийн задаргаа, 4.4- үйл ажиллагаа бүрийн цалин хөлсний задаргаа, 4.5- үйл ажиллагаа бүрийн нөхөн төлөгдөх зардал маягтууд) жишиг маягтын дагуу бэлтгэнэ. 4.7.2. Техникийн саналд дурьдсан үйл ажиллагаатай холбоотой зардлууд зардлын тооцоололд тусгаагүй тохиолдолд түүнийг бусад үйл ажиллагааны зардалд багтсан гэж үзнэ.
ТӨЗ 4.8	Татвар [Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд төлөх татвар, хураамжийн талаарх мэдээллийг бичнэ]:
ТӨЗ 4.9	Зөвлөх санхүүгийн саналыг [валютыг³ зааж өгнө] илэрхийлнэ.
ТӨЗ 4.10	Санхүүгийн санал нь түүнийг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [30] хоног буюу [он, сар, өдөр] хүртэл хүчинтэй байна.
ТӨЗ 5.4	Тендерийг баталгаажуулах, илгээх: 1. Тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлгийн 4.1 маягтыг тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй. 2. Тендерт оролцогч нь өөрийн бэлтгэсэн техникийн болон санхүүгийн саналыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ээр илгээнэ.
ТӨЗ 5.5	Саналыг 201__ оны __-р сарын __-ны өдрийн __ цаг __ минутаас өмнө ирүүлсэн байх ёстой.
ТӨЗ 5.7	Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 1. Маягт 3.1-техникийн санал ирүүлэх 2. Маягт 3.2 Зөвлөхийн танилцуулга 3. Маягт 4.1 Санхүүгийн санал 4. Тендерийн баталгааны маягт 5. Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТӨХ-ийн 4.5-д заасан бүх баримт бичиг 6. Байгууламжийн талаарх зөвлөхийн санал, зөвлөмж 7. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга 8. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт 9. Санал болгож буй мэргэжилтний намтар(CV)-ын жишиг маягт 10. Ажиллах хүчний ажиллах хуваарь 11. Ажлын хуваарь 12. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй


³ Валют нь 2-оос дээшгүй байвал зохино.

баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг доорх хүснэгтийн дагуу боловсруулж нууцлахгүйгээр ирүүлнэ.

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		

ТӨЗ 6.2	БХТС-ын Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:	Оноо
(1)	Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага: [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]	[5-10]
(2)	Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]	[20-40]
(3)	Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]	[15-30]
	Дээрх 3 шалгуур үзүүлэлт бүрийн дагуу өгөх оноо нь дараахь 3 дэд үзүүлэлтийн эзлэх хувийн жинд нийцсэн байх ёстой:	
	(1) Ерөнхий чадвар	[20-30%]
	(2) Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар	[40-50%]
	(3) Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага	[10-20%]
	<u>Нийт хувийн жин:</u>	100%
(4)	Мэдлэг дамжуулах хөтөлбөрийн тохиромжит байдал (сургалт) [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]	[0-10]
(5)	Дотоодын мэргэжилтний оролцоо (гадаадын болон дотоодын зөвлөхийн санал болгосон голлох мэргэжилтнүүдийн иргэншлийн байдалд тулгуурлана: 10 онооноос үл хэтэрнэ.) [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]	100
	<u>Нийт оноо:</u>	
	Авбал зохих техникийн доод оноо: 70	
	ХТС-ын Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:	Оноо
1)	Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал [дэд үзүүлэлт]	[20-30]

	<p>[дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]</p> <p>2) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага: [15-40] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]</p> <p>3) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага [15-30] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт] [дэд үзүүлэлт]</p> <p>Дээрх шалгуур үзүүлэлт бүрийн дагуу өгөх оноо нь дараахь дэд үзүүлэлтийн эзлэх хувийн жинд нийцсэн байх ёстой:</p> <table> <tr> <td>1. Ерөнхий чадвар</td> <td>[20-30%]</td> </tr> <tr> <td>2. Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар</td> <td>[50-60%]</td> </tr> <tr> <td>3. Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага</td> <td>[10-20%]</td> </tr> </table> <p><u>Нийт хувийн жин:</u> 100%</p> <p>Авбал зохих техникийн доод оноо: 70</p>	1. Ерөнхий чадвар	[20-30%]	2. Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар	[50-60%]	3. Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага	[10-20%]
1. Ерөнхий чадвар	[20-30%]						
2. Тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвар	[50-60%]						
3. Хэлний болон бүс нутгийн мэдлэг, туршлага	[10-20%]						
ТӨЗ 6.6	<p>Үнийг хөрвүүлэх валют: _____</p> <p>Монголбанкны албан ёсны ханш: _____</p> <p>Огноо: _____</p>						
ТӨЗ 6.3	<p>Чанарын үнэлгээний арга болон санхүүгийн санал: <i>Чанарын үнэлгээний аргыг ашигласан тохиолдолд хамгийн өндөр техникийн оноо авсан зөвлөхтэй тендерийн өгөгдөлийн хүснэгт болон зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгын 1.2-т заасны дагуу түүний ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналд үндэслэн уг санал болон гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийнэ. Шууд гэрээ байгуулах аргыг ашигласан тохиолдолд мөн энэ заалтыг мөрдөнө.</i></p>						
ТӨЗ 6.7	<p>Санхүүгийн саналын оноог дараах томъёогоор тооцоолж гаргана: [$Sf=100 \times Fm/F$] Sf - санхүүгийн саналын оноо, Fm - хамгийн бага үнэ бүхий санхүүгийн санал, F - тухайн зөвлөхийн санал болгосон үнэ]</p> <p>Техникийн болон санхүүгийн саналын хувийн жин (T+P=1)²:</p> <p>T=</p> <p>P=</p>						



² Олон улсын практикт ихэнх тохиолдолд техникийн саналд 0.7-0.9, харин санхүүгийн саналд 0.1-0.3-ын хооронд хувийн жин өгдөг.

ТӨЗ 7.1	Хэлэлцээр хийх газрын хаяг:
Гэрээ байгуулах эрх олгох, мэдэгдэл хүргэсэнд тооцох	
ТШЗ 8.1	Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн IV бүлгийн санхүүгийн санал-жишиг маягтуудын 4.1. САНХҮҮГИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТАД зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.
ТӨЗ 8.2	Зөвлөх үйлчилгээг [он, сар, өдөр]-ны өдөр [байршил]-д эхлүүлнэ:
ТӨЗ 9.1	<p>[Дараах сонголтуудаас аль тохирохыг үлдээ]</p> <p>(а) Гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй;</p> <p style="padding-left: 40px;">эсвэл</p> <p>(б) Тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна.</p>

Санхүүгийн хэлэлцээр⁵

Цалин хөлсний үнийн задаргаа

Нэг. Цалин хөлс



1.1 Ажилтнуудад олгох цалин хөлсөнд цалин, нийгмийн хамгааллын зардал, нэмэлт зардал, ашиг болон үндсэн ажлын байрнаас гадна ажилласан аливаа томилолтын зардал орно. Санхүүгийн хэлэлцээрт бэлтгэхэд зөвлөхөд туслах зорилгоор цалин хөлсний задаргааг харуулсан жишиг маягыг хавсаргав (Техникийн саналд үнийн тухай мэдээллийг оруулахгүй). Тохиролцсон цалин хөлсний задаргааг харуулсан хүснэгт нь хэлэлцэж тохирсон гэрээний нэг хэсэг болно.

1.2 Захиалагч хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор зөвлөхийн санхүүгийн санал аль болох бодитой байхад анхаарна. Хэлэлцээрийн үед тухайн зөвлөхийн санал болгосон цалин хөлсийг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд үндэслэж магадлана. Зөвлөх сүүлийн гурван жилийн баталгаажуулсан санхүүгийн тайланг, дүгнэлтийн хамт ирүүлж, түүний санал болгосон цалин хөлс болон бусад үнийг захиалагч нарийвчлан хянах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрнө. Цалин хөлсний зардлын задаргааг дор тайлбарласан болно.

(1) Цалин

Энэ нь зөвлөхийн ажилтнуудын үндсэн ажлын байранд ажилласан нийт үндсэн цалин. Энэ зардалд томилолтын хөлс, шагнал, урамшуулал (хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол)-ыг оруулахгүй.

(2) Шагнал

Шагналыг ихэвчлэн ашгаас төлдөг. Иймд ажилтнуудад олгох шагналыг цалин хөлсний зардалд оруулахгүй. Зөвлөхийн үндсэн үйл ажиллагаа явуулж буй улсын нягтлан бодох бүртгэлийн систем нь нийгмийн хамгааллын болон бусад зардлыг нийт орлогоос хувиар тооцдог бол эдгээр хувиудыг үндэслэж тооцно. Тухайн орны төрийн бодлогын хэмжээнд ажилтанд 13 дахь сарын цалинг төлөхийг шаарддаг бол түүнээс ашиг тооцохгүй. Шагналтай холбоотой асуудлыг аудитаар баталгаажуулсан баримт бичигт үндэслэн хэлэлцэх ба эдгээр баримт бичгийн нууцлалыг хадгална.

(3) Нийгмийн хамгааллын зардал

Нийгмийн хамгааллын зардал нь ажилтнуудад мөнгөн бус хэлбэрээр очих урамшуулал юм. Үүнд тэтгэврийн, эрүүл мэндийн болон амь насны даатгалаас гадна түр хүчээ алдсаны тэтгэмж болон амралтын цалин хамаарна. Зөвлөхийн үйлчилгээний хугацаанд нийтээр амрах баяр ёслолын өдрийн цалин болон ажилтан орлон ажиллаагүй зардлыг нийгмийн хамгааллын зардалд оруулахгүй.

(4) Чөлөөний зардал

Үндсэн цалинд харьцах жилийн чөлөөний зардлыг дараах байдлаар тооцно:

$$\text{Чөлөөний зардал}^6 (\text{цалингаас бодох \%}) = \frac{\text{нийт чөлөөний хоног} * 100}{\text{-----}}$$

⁵ Чанарын үнэлгээний арга болон шууд гэрээ байгуулах аргын үед ашиглана.

[365-w-ph-v-s];

Зөвхөн захиалагч чөлөөний зардлыг тусад нь төлөхгүй бол энэ зардлыг нийгмийн хамгааллын зардалд оруулдаг болохыг анхаарах хэрэгтэй.

(5) Нэмэлт зардал

Нэмэлт зардал гэдэг нь тухайн зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд гарсан зардалтай шууд холбоогүй, гэрээнд тусгай зүйл болж нөхөн төлөгдөхгүй, тухайн зөвлөхийн бизнесийн зардлыг хэлнэ. Нэмэлт зардалд ихэвчлэн ажлын байранд гарсан зардал (хамтрагчийн ажилласан цаг, цалингүй ажилласан цаг, ахлах ажилтны төслийг удирдахад зарцуулсан цаг, түрээс, туслах ажилтан, судалгаа шинжилгээ, сургалт, маркетингийн зэрэг зардал), ашгийн төлөө төсөлд ажиллаагүй ажилтны зардал болон бизнесийн урамшууллын зардлууд багтана. Зөвлөх хэлэлцээрийн үед хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон сүүлийн гурван жилийн нэмэлт зардлыг зүйл бүрээр ангилж, үндсэн цалинд харьцах хувийг гарган, хэлэлцээр хийх үед танилцуулах боломжтой байх ёстой. Захиалагч зөвлөхийн үндсэн бус ажилтны нийгмийн болон нэмэлт гэх мэт зардлыг хүлээн зөвшөөрөхгүй. Энэ тохиолдолд зөвхөн захиргааны зардал болон туслах гэрээгээр ажиллах ажилтанд олгох сар бүрийн төлбөрийг оруулан тооцож болно.

(6) Ашиг

Цалин, нийгмийн хамгааллын зардал болон нэмэлт зардлын нийлбэрээс ашгийг тооцно. Тогтмол олгодог шагнал байгаа бол түүнийг ашгаас хасч тооцно. Нөхөн төлөгдөх зардлаас өндөр үнэтэй тоног төхөөрөмж худалдан авахаас бусад тохиолдолд дээрх зардал болон томилолтын зардлаас ашиг тооцохгүй. Захиалагч гэрээний төсөлд заасны дагуу урьдчилан тохиролцож тооцсон төлбөрийн хуваарийг үндэслэн төлбөрийг хийнэ гэдгийг анхаарах ёстой.

(7) Томилолтын зардал

Зарим зөвлөх төв байрнаас гадна ажиллаж буй ажилтанд томилолтын зардал олгодог. Энэ зардал нь цалингийн хувиар тооцогдох ба түүн дээр нэмэлт зардал болон ашиг нэмж тооцохгүй. Зарим орны хуулиар томилолтын зардлаас нийгмийн хамгааллын зардлыг тооцдог. Энэ тохиолдолд томилолтын зардал болон түүнээс бодогдсон нийгмийн хамгааллын зардлыг нийт нийгмийн хамгааллын зардалд тусгай зүйл болгон харуулна. Холбогдох ажилтны хувьд энэ зардалд гэрээр боловсрол эзэмших зэрэг зардлууд орсон байх ба уг зардал болон түүнтэй адилтгах зүйлсийг нөхөн төлөгдөх зардал гэж үзэхгүй.

(8) Өдөр хоногийн зардал

Өдөр хоногийн зардлыг цалин хөлсөнд оруулалгүй тусгай зүйл болгон төгрөгөөр төлбөрийг хийнэ. Энэ зардлыг ажилтны тэтгэмжид байдаг хүмүүст төлөхгүй бөгөөд гэр бүлтэй, гэр бүлгүй гэж ялгалгүй адил төлнө.


Хоёр. Нөхөн төлөгдөх зардал

2.1 Санхүүгийн хэлэлцээрээр нөхөн төлөгдөх зардлыг авч хэлэлцэнэ. Эдгээр зардалд судалгаа, тоног төхөөрөмж, байрны түрээс, бичиг хэрэг, олон улсын болон орон нутгийн аялал, компьютерийн түрээс, ажлыг эхлүүлэх, дуусгах, даатгал, хэвлэх болон бусад зардлуудыг хамруулж болно. Эдгээр зардал нь тогтмол, эсхүл нөхөн төлөгдөхөөр байх ба гадаадын болон үндэсний валютаар илэрхийлэгдсэн байж болно.


⁶ w=амралтын, ph=нийтийн баяр ёслолын, v=ээлжийн амралтын, s=өвчтэй байсан өдөр.

Гурав. Банкны баталгаа

3.1 Зөвлөхөд төлөх төлбөр болон аливаа урьдчилгаа төлбөр нь урьдчилан тохиролцсон төлбөрийн хуваарь болон ажил, үйлчилгээ нь төлөвлөгөөний дагуу явагдаж буйд үндэслэн дотоод болон гадаад валютаар хийгдэнэ. Урьдчилгаа төлбөр нь урьдчилан тооцсон бэлэн мөнгөний урсгалын тооцоонд үндэслэн хийгдэх бөгөөд банкны баталгаагаар баталгаажсан байна.



[Төслийн нэр:]
[Зөвлөх үйлчилгээний нэр]



ТОХИРОЛЦСОН ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАДАРГАА⁷

[Валют⁸: _____]

Зөвлөх	1	2	3	4	5	6	7	8
Нэр, албан тушаал	Үндсэн цалин ⁹	Нийгмийн хамгааллын зардал (1*)	Нэмэлт зардал (1*)	Бүгд	Ашиг (4*)	Томилолт (1*)	Тохиролцсон нийт цалин хөлс	Нэгж цалин хөлс (1-ийн_%)
Томилолт								
Ажлын байр								

Зөвлөхийн гарын үсэг: _____ / _____ / Огноо: _____

Эрх бүхий этгээдийн гарын үсэг _____ / _____ /

Нэр: _____

Албан тушаал: _____

⁷ Энэ жишиг хүснэгтийг зөвхөн хэлэлцээр хийхэд ашиглах бөгөөд техникийн, эсхүл санхүүгийн саналын нэг хэсэг болохгүй.

⁸ Валют тус бүрд нэг хүснэгт хэрэглэнэ.

⁹ Сар, өдөр, эсхүл цагаар.


ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ТЕХНИКИЙН САНАЛ – ЖИШИГ МАЯГТУУД



- 3.1. Техникийн санал ирүүлэх маягт
- 3.2. Зөвлөхийн танилцуулга
- 3.3. Ажлын даалгавар болон захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн талаарх зөвлөхийн санал, зөвлөмж
- 3.4. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга
- 3.5. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт
- 3.6. Санал болгож буй мэргэжилтний намтар(CV)-ын жишиг маягт
- 3.7. Ажиллах хүчний ажиллах хуваарь
- 3.8. Ажлын хуваарь

3.1. ТЕХНИКИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ



(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай **[он, сар, өдөр]**-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид **[Зөвлөхийн үйлчилгээний нэр]** үзүүлэхээр санал болгож байна. Бид техникийн болон санхүүгийн саналаа тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж үүгээр хүргүүлж байна.

Саналын хүчинтэй байх хугацаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **[30]** хоногийн дотор буюу **[он, сар, өдөр]**-аас өмнө хэлэлцээр хийгдэх бол санал болгож буй ажилтнуудад үндэслэж оролцоно. Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:


Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

3.2. ЗӨВЛӨХИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын чадварыг харуулж чадах сүүлийн 5 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл



Доорх хүснэгтийн дагуу танай байгууллагын дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Зөвлөх үйлчилгээний нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүнс-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Зөвлөх үйлчилгээний өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан зөвлөхийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан зөвлөхийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Зөвлөх компанийн нэр: _____

3.3. АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОН ЗАХИАЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХ ЗӨВЛӨХИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ



Ажлын даалгаврын хувьд:

- 1.
- 2.

Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн хувьд:

- 1.
- 2.


**3.4. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР
БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

1. Техникийн болон удирдах ажилтнууд			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил

2. Туслах ажилтнууд			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил

**3.6. САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ
НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ**



Санал болгож буй албан тушаал: _____
Байгууллагын нэр: _____
Мэргэжилтний нэр: _____
Мэргэжил: _____
Төрсөн он, сар, өдөр: _____
Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____
Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____
Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]


Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____
Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

3.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

Нэр	Албан тушаал	Тайлан гаргах	Сарууд (хөндлөн зураасаар тэмдэглэх)												Сар	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Гадаадын зөвлөх																
1																
2																
3																
Дотоодын зөвлөх																
1																
2																
3																



Үндсэн ажилтнаар: _____
 Тайлангийн тоо: _____
 Гүйцэтгэх хугацаа: _____

Цагийн ажилтнаар: _____

Гарын үсэг:


(Эрх бүхий этгээдийн)

Овог нэр: _____

Албан тушаал: _____

Хаяг: _____

3.8. АЖЛЫН ХУВААРЬ




А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

	[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үйл ажиллагаа (ажлууд)												

В. Ажлыг дуусгаж тайлан өгөх


Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	
2. Явцын тайлан (а) 1 дэх тайлан (б) 2 дахь тайлан	
3. Тайлангийн төсөл	
4. Эцсийн тайлан	

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
САНХҮҮГИЙН САНАЛ - ЖИШИГ МАЯГТУУД



- 4.1. Санхүүгийн санал өгөх маягт
- 4.2. Зардлын товчоо
- 4.3. Үйл ажиллагаа бүрийн үнийн задаргаа
- 4.4. Үйл ажиллагаа бүрийн цалин хөлсний задаргаа
- 4.5. Үйл ажиллагаа бүрийн нөхөн төлөгдөх зардал

4.1. САНХҮҮГИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ



(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай **[он, сар, өдөр]**-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид **[зөвлөхийн үйлчилгээний нэр]**-г **[санхүүгийн саналын дүнг тоогоор болон үсгээр бичнэ]** төгрөгөөр гүйцэтгэхээр санал болгож байна. Энэ үнэд **[татварын дүнг тоогоор болон үсгээр]** төгрөгийн дотоодын татвар, хураамж орсон болно.

Саналын хүчинтэй байх хугацаа нь санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **[30]** хоногт буюу **[он, сар, өдөр]**-аас өмнө хийгдэх гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд бидний санхүүгийн санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

4.2. ЗАРДЛЫН ТОВЧОО



Зардал	Валют ¹⁰	Дүн
.....		
Дүн		
Дотоодын татвар, хураамж		
Санхүүгийн саналын нийт дүн		_____


4.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН ҮНИЙН ЗАДАРГАА

Үйл ажиллагааны № _____ нэр _____

Үнэ	Валют	Дүн
Цалин хөлс		
Нөхөн төлөгдөх зардал		
Магадлашгүй зардал		
Бүгд		_____

¹⁰ Төгрөг болон 3-аас илүүгүй бусад валют.

4.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАДАРГАА



Үйл ажиллагааны № _____ нэр _____

Нэрс	Албан тушаал	Оролцоо ¹¹	Цалин хөлсний нэгж үнэ	Дүн
Үндсэн ажилтнууд				
Дотоодын ажилтнууд				
Зөвлөхүүд				
Бүгд дүн				_____

4.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН НӨХӨН ТӨЛӨГДӨХ ЗАРДАЛ

Үйл ажиллагааны № _____ нэр _____

№	Зардлын зүйл	Нэгж	Тоо, хэмжээ	НБҮнэ	Нийт дүн
1.	Олон улсын нислэг _____	Аялал			
2.	Аялалын бусад зардал	Аялал			
3.	Томилолтын зардал	Өдөр			
4.	Дотоодын тээврийн зардал ¹²				
5.	Байрны түрээс (буудлын зардал)				
	Бүгд дүн				_____

¹¹ Хүн-сар, хүн-өдөр, эсхүл хүн-цаг.

¹² Хэрэв захиалагч дотоодын тээврийг хариуцах бол энэ зардлыг тусгахгүй. Мөн байрны түрээс(буудлын зардал)-ийн зардлыг захиалагч олгосон бол энэ зардлыг тусгахгүй.

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР МАЯГТ
(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)**

(Санамж:Захиалагчийн үнэлгээний хороо нь худалдан авах зөвлөх үйлчилгээний онцлогт тохируулан энд тусгагдаагүй асуудлыг гэрээний маягт болон тусгай нөхцлийг боловсруулж, тендерт илгээх үүрэг хүлээнэ)

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

ЗӨВШӨӨРСӨН:

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

[Зөвлөх үйлчилгээний нэр] гэрээ.

Дугаар № [гэрээний дугаар]

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [зөвлөхийн нэр] (цаашид "зөвлөх" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) 202...оны _____сарын ...-ны өдөр байгуулав.

1.Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № -д тодорхойлсон "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ"-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.

2.Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид "ажил" гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

3.2.Нийт санхүүжилт:

Үүнээс. 202... онд санхүүжих дүн:

4.Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Нэгдүгээр хавсралт: Гэрээний ерөнхий нөхцөл;

Хоёрдугаар хавсралт: Гэрээний тусгай нөхцөл;

Гуравдугаар хавсралт: Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ;

Дөрөвдүгээр хавсралт: Тайлан гаргах хуваарь;

Тав дугаар хавсралт: Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь;

Зургаадугаар хавсралт:Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг;

Долоо дугаар хавсралт: Захиалагчийн хүлээх үүрэг;

Наймдугаар хавсралт: Урьдчилгаа төлбөрийн баталгаа;

Есдүгээр хавсралт:Гүйцэтгэлийн баталгаа;

[Тэмдэглэл: Дээр дурдсан хавсралтаас тухайн гэрээнд хэрэглэхгүй тохиолдолд түүнийг хасч бичнэ.]

5.Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

6. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

8. Зөвлөх үйлчилгээ нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

9. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, тендерийн баримт бичигт заасан "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ", зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх зардлын нэр төрөл, тоо хэмжээ зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

10. Захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 9 дэх хэсэгт зааснаас бусад болон гэрээний ерөнхий нөхцлийн 2.4, 2.5 дахь хэсэгт заасан нөхцлийг үндэслэн гэрээнд зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

11. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

12. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

13. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

14. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

III. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

(Хаалтанд байгаа зүйлийг { } сонгон хэрэглэнэ; эцэслэн боловсруулалт хийхэд тэмдэглэлийг хасна)

Төсөл арга хэмжээний нэр:

Тендер шалгаруулалтын дугаар:

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.3	Гэрээний баримт бичгүүд нь [хэл] хэл дээр байна.
1.4	Захиалагчийн хаяг: Захиалагч: Харилцах хүн: Утас: Факс: Захиалагч: Харилцах хүн: Утас: Факс: И-мэйл:
{1.6}	{Төлөөлөх эрх бүхий гишүүн [гишүүний нэрийг оруул] <u>Тэмдэглэл:</u> Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Зөвлөх дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.
1.7	Итгэмжлэгдсэн төлөөлөгчид: Захиалагчийн: Зөвлөхийн:
1.8	Татвар [Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд төлөх татвар, хураамжийн талаарх мэдээллийг бичнэ]: <u>Тэмдэглэл:</u> Гэрээнд хэрэглэх хуулийн дагуу зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтнуудын төлбөл зохих татвар хураамж болон эсхүл захиалагч нөхөн олгох буюу эсхүл тодорхой татвар, хураамж төлбөрөөс чөлөөлөгдөх ёстой зэргийг энд оруулна.

{2.1}	<p>{Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: [огноог оруул]}</p> <p>Тэмдэглэл: Гэрээ хүчин төгөлдөр болох огноо нь санхүүжүүлэгч байгууллагын зөвшөөрөл зэрэг нэмэлт нөхцөлөөс хамааралтай байж болно. Талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бол ГТН-ийн энэ хэсгийг бүхэлд нь хасна.</p>
2.2	<p>Үйлчилгээг эхлэх хугацаа: [хугацааг оруул, жишээлбэл: нэг сар г.м].</p>
2.3	<p>Гэрээний хугацаа дуусгавар болох өдөр: ...он ...сарын-ны өдөр</p>
2.5.1	<p>Гэрээний хугацаа сунгах: Гэрээний ерөнхий нөхцлийн 2.5-т заасан нөхцөл байдал үүсвэл гэрээг сунгах буюу үргэлжлүүлэх шийдвэрийг захиалагч гаргана.</p>
2.6	<p>Гэрээг цуцлах: Гэрээний ерөнхий нөхцлийн 2.6 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүсвэл талуудын санаачлагаар гэрээг цуцлана.</p>
3.4	<p>Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:</p> <ul style="list-style-type: none"> (а) Машин механизм, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгалд зөвлөхийн доод хэмжээ нь [мөнгөн дүн] байна. (б) Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна. (в) Мэргэжлийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна. (г) Гэнэтийн ослын, амь нас, эрүүл мэндийн хувьд гэрээнд хэрэглэх хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна. <p>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагтай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх эсхүл хэглэхгүй заалтыг хасна.</p>
{3.5 (в)}	<p>{Бусад үйл ажиллагаа : Зөвлөх нь гэрээний ерөнхий нөхцлийн 3.5-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд: [захиалагчийн шаардлагтай гэж үзсэн үйл ажиллагааг оруул].}</p> <p>(в) Жишээлбэл: Зураг төсөл, өртгийн төсвийг магадлалд оруулах, загвар зураг гаргах, олон нийтийн хэлэлцүүлэгт оруулах гэх мэт</p>
{5.1}	<p>Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана: ГЕН-ийн 5.1 зүйлд заасны дагуу захиалагчийн зүгээс үзүүлэх тусламж дэмжлэг, зөвшөөрөлийн жагсаалтыг оруул. Ийм зүйл байхгүй бол ГТН-ийн энэ хэсгийг бүхэлд нь хасна.</p>
6.2(a)	<p>Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн дээд хэмжээ: [мөнгөн тэмдэгт бүрээр хэмжээг тоо болон үсгээр оруул]</p>

6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>[хэмжээг тоо болон үсгээр оруул]</i>
6.4	<p>Төлбөр хийх данснууд: Гадаад мөнгөн тэмдэгийн хувьд: <i>[дансны нэр, дугаарыг оруул]</i>. Төгрөгийн хувьд: <i>[дансны нэр, дугаарыг оруул]</i>.</p> <p>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө. <i>Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь хаирлцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө</i></p> <p>(а) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг, урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлсэн тохиолдолд үйлчилгээг эхлүүлэх өдөр төлнө. (б) Гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх дүнг эхлэлтийн тайлан ирүүлсний дараа төлнө. (в) Гэрээний үнийн дүнгийн 25 хувьтай тэнцэх дүнг дунд хугацааны тайлан ирүүлсний дараа төлнө. (г) Гэрээний үнийн дүнгийн 25 хувьтай тэнцэх дүнг эцсийн тайлангийн төслийг ирүүлсний дараа төлнө. (д) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг эцсийн тайланг хүлээн зөвшөөрсний дараа төлнө. (е) Гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг төлснөөр гэрээний гүйцэтгэлийн баталгааг цуцлаж болно.</p> <p><i>Тэмдэглэл: Энэхүү зүйлийг гэрээ бүрийн шинж чанарт тохируулан боловсруулах ёстой.</i></p>
6.5	<p>Хүүгийн хувь хэмжээ: Захиалагч нь ГТН-ийн 6.4–д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг зөвлөхөд төлнө.</p> <p>Хүүгийн хувь хэмжээ: Зөвлөх нь ГТН-ийн 2.3–т–д тогтоосон эцсийн тайлан гаргах, зөвлөх үйлчилгээг захиалагчид хүлээлгэн өгөх хугацааг арван таван (15) хоногоос дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,4 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.</p>
8	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд гэрэний ерөнхий нөхцлийн 8.1, 8.2-т заасан журмаар шийдвэрлэнэ.

IV. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ №1 – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Тэмдэглэл: Энэхүү хавсралт нь техникийн хэлэлцээрийн явцад захиалагч болон зөвлөхийн эцэслэн тохиролцсон ажлын даалгавар, тодорхой ажлуудыг дуусгавар болгох огноо, зарим ажлуудыг гүйцэтгэх байршил, захиалагчийн зөвшөөрлийг авбал зохих тодорхой ажлуудын талаарх мэдээллийг агуулна.

ХАВСРАЛТ №2 - ТАЙЛАН ГАРГАХ ХУВААРЬ

Тэмдэглэл: Тайлангийн агуулга болон түүнийг гарган ирүүлэх маягт, давтамж: хүлээн авах хүн: ирүүлэх огнооны талаарх мэдээллийн жагсаалт.

ХАВСРАЛТ №3 - ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТЭН БОЛОН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ

Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:

- C-1 Үйлчилгээ үзүүлэх гадаадын голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*
- C-2 Үйлчилгээтэй холбоотой ажлыг гадаадад гүйцэтгэх голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*
- C-3 Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн жагсаалт: тэдгээрийн голлох ажилтантай холбоо бүхий дээрх хавсралт бүртэй ижил мэдээлэл*
- C-4 Дотоодын голлох мэргэжилтний талаарх дээрхийн ижил мэдээлэл.*

ХАВСРАЛТ №4 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА (ГАДААД МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР)

Тэмдэглэл: Гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:

- 1. Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)*
- 2. Нөхөн төлөгдөх зардал.*

Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.

**ХАВСРАЛТ №5 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА
(ТӨГРӨГӨӨР)**



Тэмдэглэл: Төгрөгөөр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:

1. Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)
2. Нөхөн төлөгдөх зардал.

Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.

ХАВСРАЛТ №6 - ЗАХИАЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:

- №-1** Захиалагчийн зүгээс зөвлөхөд үзүүлэх үйлчилгээ, байгууламж болон эд хөрөнгө.

ХАВСРАЛТ №7 - УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН
БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]



[Зөвлөхийн нэр] (цаашид “зөвлөх” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот [Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт] гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 6.4 заалтын дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж [Захиалагчийн нэр]-ийн өмнө хариуцлага хүлээж [Баталгааны мөнгөн дүн] [үсгээр]¹⁶-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь зөвлөхийн нэрийн өмнөөс [баталгааны дүн тоогоор, валют] [дүн үсгээр, валют]¹⁷-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, зөвлөх гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, зөвлөхийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу үзүүлэх зөвлөх үйлчилгээ, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу зөвлөхөд урьдчилгаа төлбөр хийгдсэн өдрөөс захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдтөл хүчин төгөлдөр байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹⁶ Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

¹⁷ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу [Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт] (цаашид "гэрээ" гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид "Банк" гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс [баталгааны дүн тоогоор, валют] [дүн үсгээр, валют]¹⁸ –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг [захиалагчийн нэр] (цаашид "захиалагч" гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан [баталгааны дүн тоогоор, валют] [дүн үсгээр, валют]-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹⁸ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар
сарын 09-ны өдрийн А/436 дугаар
захирамжийн зургаа дугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ,
ГЭРЭЭНИЙ МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 146 дугаар тушаалын хавсралтаар баталсан, Сангийн сайдын 2022 оны 138 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулав.

2022 он



II БҮЛЭГ. ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

Санамж

Захиалагч авах зөвлөхөөс бусад үйлчилгээний онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн үйлчилгээ үзүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

**II БҮЛЭГ. ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

Төсөл арга хэмжээний нэр:

Төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын дугаар:



ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: [захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: [төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, дугаарыг бүтэн бичих]
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: [цахим системд заасан тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бичих]
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц № 1: багцын нэр, Багц № 2: багцын нэр... гэх мэт.
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: [эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгө гэх зэргээр тодорхой, товчлохгүй бичих]
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: [мөнгөн дүн бичих] [Хэрэв багцад хуваасан бол багц тус бүрийн төсөвт өртгийг бичих: Багц №...: _____ Багц №...: _____]
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 8.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: [хариуцсан ажилтны албан тушаал, нэрийг бичих] Хаяг: [хүсэлт хүлээн авах хаягийг бичих] Утасны дугаар: [албан байгууллагын утасны дугаарыг бичих] Цахим шуудангийн хаяг: [албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бичих]
ТШЗ 9.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих. Хэрэв "Тийм" бол уулзалт болох газар, огноо, цагийг бичих]
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ["Монгол хэл" эсхүл аль нэг гадаад хэлийг сонгож бичих]
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: ["Зөвшөөрнө" эсхүл "Зөвшөөрөхгүй" гэж бичих].
ТШЗ 16.1	Ерөнхий нөхцлийг магадлах: ТШЗ-ийн 16.1, ТШЗ 16.2.1, ТШЗ 16.2.2, ТШЗ 16.2.3, 16.2.4 дэх хэсгүүдэд заасан баримт бичгийг үндэслэн тендерт оролцогч түүний түншлэгчдийн ерөнхий нөхцлийг магадлана. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу хуульд

	заасан ерөнхий нөхцөлийг хангасан болохыг V бүлгийн Error! Reference source not found.-ийн дагуу ирүүлнэ.
ТШЗ 16.2.1	<p>Тендерт оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд иргэний хэрэг, маргаанд оролцсон эсэх талаарх тодорхойлолт: "Шаардлагатай" Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим хэлбэрээр авна.</p> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 16.2.2	<p>Тендерт оролцогчтой холбоотой шүүхийн шийдвэрийн ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт шаардлагатай эсэх: "Шаардлагатай"</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж архивын лавлагаа авах хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт илгээх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хянан үзэж цахим хэлбэрээр ирүүлдэг болохыг анхаарна.уу!</p> <p>Жич: Дээрх тодорхойлолт авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу</p>
ТШЗ 16.2.3	<p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем" www.tender.gov.mn болон "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p>/Тендерт оролцогчийн өөрийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</p>
ТШЗ 16.2.4	Эрх бүхий болохыг нотлох баримт бичиг: Улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй.
ТШЗ 17.2	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: ТШЗ-ийн 17.2.1, 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5, 17.3 дахь хэсгүүдэд заасан шалгуур үзүүлэлтээр санхүүгийн чадавхийг үнэлнэ.
ТШЗ 17.2.1	<p>Харилцагч бакны өр төлбөргүй талаарх лавлагаа: "Шаардана":</p> <p>Хугацаа хэтэрсэн зээл, өр, төлбөртэй эсэх талаарх Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагааг өөрийн харилцагч банкнаас авч тендерт ирүүлнэ.</p>
ТШЗ 17.2.3	Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
ТШЗ 17.2.4	Санхүүгийн тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын мэдээлэл: Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 онууд)-ийн

	<p>борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх ба тендерт оролцогч (түүний түншлэгчид) нь өөрийн хариуцах үүрэгт ноогдох дүнгээр дээрх үзүүлэлтийг хангана. эдгээр онуудад ашигтай ажилласан байна.</p>
ТШЗ 17.2.5	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана” Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ <ul style="list-style-type: none"> • Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээл олгох боломжтой тухай тодорхойлолт ирүүлнэ. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;</p>
ТШЗ 17.3	<p>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг үнэлгээнд ашиглана. Дээрх онуудын санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй. Тендерт оролцогчийн санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж санхүүгийн чадавхийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг шалгана. Тендерт оролцогч нь эдгээр онуудад ашигтай ажилласан байна.</p>
ТШЗ 17.6	<p>Тендерт оролцогчийн техникийн чадавхийг ТШЗ-ийн 17.6.1, 17.6.2, 17.6.3, 17.6.4, 17.6.5 дахь хэсэгт заасан туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага болон үүгээр хязгаарлахгүйгээр үнэлгээний хорооноос хуульд нийцүүлэн тогтоосон бусад үзүүлэлтээр үнэлнэ.</p>
ТШЗ 17.6.1	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бичих] Тусгай зөвшөөрөл шаардсан тохиолдолд тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. Харин зарим яамд, байгууллагаас олгодог тусгай зөвшөөрлийн мэдээлэл “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем” дэх мэдээллийн санд ороогүй тул ийм ангилалд хамаарах тусгай зөвшөөрлийн эх хувь-аас татсан файлыг тендерийн баримт бичигт ирүүлнэ.</p> <p>Холбогдох тусгай зөвшөөрлийн цахим санд өөрийн компанийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл байгаа эсэхийг тендерт оролцогч нь нягтлан шалгах үүрэгтэйг анхаарна уу.</p>
ТШЗ 17.6.2	<p>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: “Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. (Хэрэв шаардах бол уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг үнэлгээний хороо тодорхой бичих ба эцэслэсэн тохиолдолд хаалтад байгаа хэсгийг устгана)</p>

1.Захиалагч хүний нөөцийн мэдээлэл шаардсан тохиолдолд уг үйлчилгээг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 4 хүснэгтийн дагуу ирүүлнэ.

2.Дээрх маягтад заасан инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг маягтын дагуу үнэн зөв гаргаж, ажилтнуудын ажлын туршлагын мэдээллийг хүн тус бүрээр баталгаажуулж ирүүлбэл зохино.

3.Энэхүү төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.

4.Тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээний мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. Ажилтан, ажилчдын сургууль төгссөн диплом, гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.

5.Төсөлд санал болгосон ажилтан, ажилчид нь гадаад улсын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн тохиолдолд диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас татсан файлыг тендерт ирүүлнэ.

6.Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, ажилчдад хамаарахгүй инженер, техникийн ажилтан, ажилчдыг төсөлд санал болгосон бол тэдэнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг тендерт ирүүлнэ. Ажил гүйцэтгэх гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.

7.Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон инженер техникийн ажилтан, ажилчид нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.

8. Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 4 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх шаардлагатай. Тендерт оролцогч нь үндсэн ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг тендер нээгдэх өдрөөс өмнөх 3 сард тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах тул нийгмийн даатгалын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.

	<p>“Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс нийгмийн даатгал төлсөн эсэх мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ</p>
<p>ТШЗ 17.6.3</p>	<p>Үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой заах]</p> <p>1. Шаардана гэж сонгосон тохиолдолд энэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж (тухайн ажлын хяналтын төсвөөр тодорхойлсон)-ийг захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтэд заасан зориулалт, шалгуур, шаардлагад нийцүүлэн санал болгоно.</p> <p>2.Бусдын өмчлөлд байгаа тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэн ашиглах тохиолдолд Монгол улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг нийцэхүйц /хөлслөх/ гэрээг төсөл хэрэгжих хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулсан байна.</p> <p>3.Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 5 хүснэгтээр санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжүүдн 50-аас доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх байх шаардлагатай.</p> <p>4.Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, холбогдох мэдээллийг тендерт ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжтэй холбоотой лавлага, бусад мэдээллийг цахим системээс шалгана.</p> <p>5.Тендерт оролцогчийн энэхүү тендерт санал болгосон тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмж нь түүний хэрэгжүүлэхээр эрх авсан болон хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ (аль нэг багц)-нд давхцан ажиллах нь тогтоогдсон тохиолдолд тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно</p>
<p>ТШЗ 17.6.4</p>	<p>Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: “Шаардлагатай”</p> <p>1. Захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 6, Маягт 7, Маягт 8 хүснэгтүүдээр ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээллийг ирүүлнэ. Гүйцэтгэл нь 100 хувьд хүрээгүй үйлчилгээг ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад тооцохгүй.</p> <p>2. Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>2.1.Сүүлийн 5 жилийн аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй/захиалагчаас санал болгосон зөвлөхийн бус үйлчилгээ түүнтэй ижил төстэй үйлчилгээний нэрийг бичих/.....Зөвлөхийн бус үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>2.2.Ижил төстэй зөвлөх бус үйлчилгээг гүйцэтгэсэн туршлагыг нотолж дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.2.1.Захиалагчтай байгуулсан гэрээ,</p>

	<p>2.2.2.Зөвлөхийн бус үйлчилгээг хүлээн авсан тухай комиссын акт (дүгнэлт)-ийн эхээс хийсэн хуулбар</p> <p>2.2.3. Дээрх ижил төсөтэй зөвлөх бус үйлчилгээнд тооцуулахаар санал болгосон үйлчилгээг гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн тухай дараах захиалагч байгууллагуудын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзнэ. Үүнд:</p> <p>2.2.3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, 45.2.2, 45.3, 45.4 дэх хэсгүүдэд заасан захиалагч байгууллага,</p> <p>2.2.3.2.Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээд</p>
ТШЗ 17.6.5	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: “Шаардана”</p> <p>Шаардана гэж захиалагч сонгосон тохиолдолд тендерт оролцогч доорх баримт бичгүүдийг өөрийн тендерт ирүүлнэ.</p> <p>1. Зөвлөхийн бус үйлчилгээний даалгавар(тодорхойлолт)-т нийцүүлэн гүйцэтгэх үүрийн үе шатны хуваарийг захиалагчаас баталсан холбогдох маягтын дагуу боловсруулж баталгаажуулан ирүүлнэ. Зөвлөхийн бус үйлчилгээ гүйцэтгэж дуусах хугацаа нь оны дугаар сарын-ны өдөр байна.</p> <p>2. Тендерт оролцогч нь энэхүү тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын болон техникийн даалгаврын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>3. Тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн гэрээний маягтад заасан нөхцөл, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг албан бичиг хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>4. Тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлсэн тендерт оролцогчийн цахим хэлбэрээр ирүүлсэн тендерийн баримт бичиг нь бичиг хэргийн холбогдох стандартыг хангаагүй, уншигдахгүй, ойлгомжгүй байх зэрэг нь тус оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч нь Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-тай танилцахыг зөвлөж байна.</p>
ТШЗ 17.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардана”</p> <p>Шаардана гэж сонгосон тохиолдолд тендерт оролцогч нь захиалагчийн тендерийн баримт бичгийн V бүлгийн тендерийн жишиг маягтуудын Маягт 7, Маягт 8 хүснэгтүүдэд өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан бүх гэрээний мэдээллийг хүснэгтийн босоо багананд заасан өгөгдлийн дагуу үнэн зөв бичиж ирүүлнэ.</p>
ТШЗ 17.8	<p>Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна.</p> <p>1.Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагын өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох дараах баримт бичгийг тендерт ирүүлэх шаардлагатай Үүнд:</p>

	<p>2.Төлөөлөх эрх бүхий этгээд болон туслан гүйцэтгэгч нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.</p> <p>3.Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх ба ТШЗ-ны 17.6.1, 17.6.2-т заасан тусгай зөвшөөрөл болон хүний нөөцийн шаардлагыг өөрийн хариуцах үүргийн хувьд хангах ёстой.</p> <p>4.Туслан гүйцэтгэгчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. Иймд улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн регистрийн дугаарын мэдээллийг тендерт ирүүлнэ.</p>
ТШЗ 17.9	<p>Тендерт оролцогч нь түншлэлтэйгээр ажил гүйцэтгэх бол дор дурьдсан нөхцөл шаардлагыг хангаж, холбогдох баримт бичгийг тендерт ирүүлнэ.</p> <p>1.Төлөөлөх эрх бүхий этгээд болон түншлэгч нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 343-349, 476 дугаар зүйлүүдийн холбогдох заалтад нийцсэн байна.</p> <p>2.Түншлэл нь ТШЗ-ны 17.2, 17.6-д заасан доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.</p> <p>3.ТШЗ-ны 17.2.4, ТШЗ-ны 17.2.5-д заасан борлуулалтын орлого, гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ, ТШЗ-ны 17.6, 17.6.1, 17.6.2, 17.7-д заасан туршлага, тусгай зөвшөөрөл, хүний нөөц, гэрээний мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийг тус тус төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.</p> <p>4.Түншлэгчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. Иймд улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тендерт ирүүлэх шаардлагагүй учир түншлэгч аж ахуйн нэгжийн регистрийн дугаарын мэдээллийг тендерт ирүүлнэ.</p>
ТШЗ 18	<p>Тендерт оролцогчийн санал болгож буй үйлчилгээ нь захиалагчийн тендерийн баримт бичгийн III бүлэгт заасан үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендертээ ирүүлнэ. Шаардлагатай бол тендер шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ)-ны 18.2 дахь хэсэгт заасан тайлбар ирүүлж болно.</p>
ТШЗ 19.2	<p>Тендерт оролцогч нь тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлтийг тооцож ирүүлнэ:</p> <p>Тендерт оролцогч III бүлэгт заасан үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагад тусгасан үйл ажиллагаа, үйл ажиллагааны хуваарьт жагсаасан үйлчилгээний бүх нэр төрлийг үнэлж ирүүлнэ.</p>
ТШЗ 19.3	<p>Тендерт оролцогч нь нэмэгдэл зардлыг тендерийн үнэнд тооцсон байна:Тендерт оролцогчийн үнийг тусгайлан тусгаж ирүүлээгүй үйлчилгээний аливаа нэр төрлийн үнэ, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тээвэрлэлтийн болон даатгалын зардал, татвар, хураамжийг</p>

	<i>тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд эдгээр зардлыг багтсанд тооцно.</i>
ТШЗ 19.6.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <i>“Тохируулахгүй тогтмол байна”</i>
ТШЗ 22.1	Тендерийн баталгааны дүн: <i>[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц тус бүрээр доорх байдлаар заана: Багц №1: [●] төгрөг; Багц №2: [●] төгрөг.]</i>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 23.5.3	ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <ol style="list-style-type: none"> 1. <i>Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;</i> 2. <i>ТШЗ-ийн 17.2-т заасан санхүүгийн чадавхийг нотлох баримт бичиг.</i> 3. <i>ТШЗ-ийн 17.6-д заасан техникийн чадавхийг нотлох баримт бичиг.</i> 4. <i>ТШЗ-ийн 17.7-д заасан Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл</i> 5. <i>ТШЗ-ийн 17.8-д заасан туслан гүйцэтгэгчийн чадавхийн мэдээлэл</i> 6. <i>ТШЗ-ийн 17.9-д заасан түншлэгчийн чадавхийн мэдээлэл</i> 7. <i>ТШЗ-ийн 18-д заасан санал болгосон ажлыг гүйцэтгэх боломжтой болохыг нотлох баримт</i> 8. <i>ТШЗ-ийн 19.2-д заасан Тендерт оролцогч нь тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт тооцсон баримт</i> ТШЗ-ийн 19.3-д заасан Тендерт оролцогч нь нэмэгдэл зардлыг тендерийн үнэнд тооцсон байна
ТШЗ 23.6	Тендерт оролцогч тендерийн баримт бичгийг нууцлах: Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 9-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
ТШЗ 24.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>[он, сар, өдрийг бичих]</i> Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бичих]</i>
ТШЗ 26.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <i>[он, сар, өдрийг бичих. Жишээ нь: 20.. оны .. дугаар сарын ..-ны өдөр]</i> Цаг: <i>[цаг, минутыг тодорхой бичих. Жишээ нь: .. цаг .. минут г.м]</i> Тендер нээх газрын хаяг: <i>[аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</i>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 30.2	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <i>["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]</i> <i>Хэрэв "Ашиглах" бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг тусгана]</i>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	

ТШЗ 36.1	Захиалагчаас тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн бүртгэлтэй мэйл хаягаар хүргүүлэх тул тендерт оролцогч нь өөрийн албан ёсны мэйл (цахим шуудангийн) хаягыг тендерийн баримт бичгийн IV бүлгийн санхүүгийн санал-жишиг маягтуудын МАЯГТ 1 буюу тендер илгээх маягтад зааж ирүүлнэ. Шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогчийн цахим шуудангийн хаягт илгээсэн өдрөөр мэдэгдлийг бичгээр хүргэсэнд тооцно.
ТШЗ 38.1	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: [“Тийм” эсхүл “Үгүй” гэж бичих] [Хэрэв “Тийм” гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих: ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]
Ё. БУСАД	
ТШЗ 41.1	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй [Хэрэв “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-аар зохион байгуулах бол “Тийм” гэж бичих]

III БҮЛЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Үйлчилгээний тодорхойлолт бэлтгэх санамж

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Үйлчилгээний тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай үйлчилгээний зорилго, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, үйл ажиллагааны хуваарь, гүйцэтгэлийн чанар шаардлагатай бусад мэдээллийг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- *Ойлгомжтой сайтар бэлтгэсэн үйлчилгээний тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- *Үйлчилгээний тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- *Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- *Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй.*

Үйлчилгээ гүйцэтгэх хуваарь

Үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж шалгахад хуваарийг ашиглана.]



**[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-
д нийтэлсэн нэг маягийн загвар үйлчилгээний тодорхойлолтын жишиг нөхцөл,
стандартыг баримтлан үйлчилгээний тодорхойлолтыг боловсруулна.]**

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 33.1.5-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Үйлчилгээг гүйцэтгэх хуваарь: [**“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих**]

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (үйлчилгээ гүйцэтгэж эхлэх хамгийн эхний өдрөөс хойш үйлчилгээ гүйцэтгэж дуусах хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) гүйцэтгэх шаардлагатай. Үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт заасан хугацаанаас өмнө үйлчилгээг гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [**хувь бичих**]-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Үйлчилгээ гүйцэтгэх хуваарьт зааснаас [**тоо бичих**]-аас илүү [**“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих**] хоцроож гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон хугацаанаас хойш гүйцэтгэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ авах тендерийн харьцуулах үнийг хэрхэн тодорхойлох шалгуур үзүүлэлтийг энд бич.

Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.]

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД



Маягт 1	Тендер илгээх маягт	1
Маягт 2	Тендерийн баталгаа (банкны)	2
Маягт 3 .. Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)		4
Маягт 4	Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл	6
Маягт 5	Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл	6
Маягт 6	Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл	6
Маягт 7	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	7
Маягт 8	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	7
Маягт 9	Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт	8

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу зөвлөхөөс бусад үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 16.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ болон тухайн үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой зөвлөхөөс бусад үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.


Маягт 2 Тендерийн баталгаа (банкны)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**



1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-аас **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн² төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. ТШЗ-ны 39 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

² Энэ дүн нь ТШЗ-ны 22.1-д заасантай ижил байна.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.]

[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]



Маягт 3 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)



Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-ийг **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**³ төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валютын төлбөрийн үүрэг хүлээх баталгааг нийт **[мөнгөн дүн]** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр болон холбогдох бусад мэдээллийг бичих]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г⁴ үндэслэн гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.

³ Энэ дүн нь ТШЗ-ны 22.1-д заасантай ижил байна.

⁴ Засгийн газрын бонд болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.




[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг заана уу.]

[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

Маягт 4

Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл



Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 5

Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]

Маягт 6

Ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/



Маягт 7 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 8 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 9

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

